

УДИРТГАЛ

Асуудал

Монгол Улсад шүүх шинжилгээний байгууллагын нэгдсэн тогтолцоо бий болох үйл явц 1998 онд “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” батлагдсанаар эхэлсэн юм. Энэхүү хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан зорилт 2005 онд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулснаар, дараа нь Засгийн газрын 2007 оны “Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай” тогтоолоор Аймгийн шинжилгээний алба байгуулах асуудлыг шийдвэрлэснээр хэрэгжсэн гэж үзэж болно.

Цагдаа, шүүх, прокурорын байгууллагахэрэг, маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явцад шинжлэх ухааны зарчимд тулгуурласан магадлагаа, дүгнэлтээр дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий, улсын хэмжээнд шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулж буй төрийн төв байгууллага бол ХЗЯ-ны харьяа Шүүхийн шинжилгээний хүрээлэн юм.

Монгол Улсад шүүх шинжилгээний үйл ажиллагаагдангаараа эрхэлдэг тус байгууллагын ажлын ачаалал их хэрнээ мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг энэхүү ажлын байранд олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн шинжээч тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаагаас үүдэн боловсон хүчний дутагдалд орох боллоо. Шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй, шинжээч дахин томилуулах тохиолдол элбэг байна. Иймд шүүх шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох боломжийг судлах нь тулгамдсан асуудлын нэг юм. Тус хүрээлэнгийн шинжээч мэргэжилтнүүд хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах үүрэгтэй хэдий ч бодит байдал дээр цагдаагийн байгууллагын нөлөө их байгаа нь ажиглагдаж байна.

Мөн эдгээр болон бусад асуудлыг шийдвэрлэж, тус салбарын үйл ажиллагаа, хөгжлийн чиг хандлагыг дэлхийн жишигт нийцүүлэх үүднээс гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны туршлага судлах, улмаар олон улсын стандартыг нутагшуулах боломж байгаа эсэхийг тандан судлах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна гэж үзлээ.

Судалгааны зорилго

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөлд зориулан боловсруулсан “Шүүх шинжилгээ” харьцуулсан судалгааны ажлын хүрээнд *forensic science* буюу шүүх шинжилгээ зүй болон *police science* буюу цагдаагийн шинжлэх ухаан гэсэн ойлголтыг тодорхойлох, шүүх шинжилгээний байгууллагын түүхэн хөгжил, бүтэц, зохион байгуулалт, хөгжлийн чиг хандлага болон мэргэжлийн шинжээчдийн эрх зүйн байдлыг хэрхэн зохицуулсан байдаг тухайд Монгол, Унгар, Солонгос, Эстони, Австрали улсын туршлага судлах, харьцуулан дүгнэх зорилго тавьж ажиллав.

Судалгааны арга зүй, судалгааны баг

Судалгааг хийхдээ холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх, гадаад орнуудын зохицуулалттай харьцуулах, задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэсэн болно. Судалгааны ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн, Э.Туулайхүү, Э. Ганчулуун нар 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Судалгааны бүтэц

Тус судалгаагаар шүүх шинжилгээтэй холбогдох олон талын асуудлыг бүхэлд нь хөндөлгүйгээр дараах хүрээнд судалсан болно. Үүнд:

1. Нэгдүгээр бүлэг, шүүх шинжилгээний тухай ерөнхий ойлголт, түүний дотор “Forensic science, forensic eximination” болон “Police science”-ийн тодорхойлолт, ойлголт
2. Хоёрдугаар бүлэг, Монгол Улс дахь шүүх шинжилгээний өнөөгийн нөхцөл байдал,
3. Гуравдугаар бүлэг, гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт,
4. Дөрөвдүгээр бүлэг, шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, мэргэжлийн шинжээчдийн эрх зүйн байдлыг харьцуулан шинжилж, нэгтгэн дүгнэсний үндсэн дээр холбогдох санал дэвшүүлэв.
5. Нэгдсэн дүгнэлт, санал гэсэн хэсгүүдтэй болно.

1 ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

1.1 Шүүх шинжилгээний тухай онолын ерөнхий ойлголт

Шинжлэх ухаан, технологийн ололтыг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглагдаараа шүүх шинжилгээ нь харьцангуй тогтвортой байдаг бөгөөд улс орон бүрт нийтлэг хөгжлийн хуультай юм. Учир нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэргийг илрүүлэх явдал нь улс орнуудын эрх зүйн тогтолцоо, нийгмийн байгуулал, хөгжлийн түвшин зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг бол шүүх шинжилгээ нь шинжлэх ухааны зарчмуудад суурилан, бодит үнэнд захирагдан хөгжиж байдаг онцлогтой. ХХ зууны эхнээс шүүх шинжилгээ нь криминалистикийн шинжилгээний бие даасан мэдлэгийн салбарыг бий болгосны зэрэгцээ магадлах эмнэлэг, магадлах ня-бо, магадлах хими, магадлах хор судлал, магадлах биологи, магадлах ДНХ, магадлах физик, магадлах инженер зүй, магадлах геологи, магадлах ургамал зүй, магадлах дижитал зүй зэрэг салбарыг эгнээндээ багтаан зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх төдийгүй иргэний болон захиргааны хэргийг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцож, бие даан хөгжих эхлэл тавигдсан байна.

Шүүх шинжилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны салбар, чиглэлтэй холбоотой судалгааны ажлууд цөөнгүй хийгдэж, тус салбарт тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг хичээж байна. Тухайлбал 2009 онд АНУ-ын Үндэсний шинжлэх ухааны академи (National Academy of Science) нь АНУ-д шүүх шинжилгээг бэхжүүлэх чиглэлээр нэгэн судалгааг хийсэн нь дэлхий дахинд шүүх шинжилгээний салбарын дэд бүтцийн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай талаар асуудал дэвшүүлсэн.¹ Судалгааны тайланд: *“Конгресс бие даасан холбооны этгээд болох шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнг үйл ажиллагаагаа явуулахад хангалттай санхүүжилтээр хангах шаардлагатай бөгөөд шүүхийн тогтолцоо шүүх шинжилгээний үр дүнд тогтоогдсон нотлох баримтыг үнэлэх, ойлгох чиглэлд хангалттай мэдлэг туршлагагүй байгааг засахад анхаарах нь зүйтэй”* зэрэг олон ач холбогдол бүхий санал, зөвлөмжийг дэвшүүлсэн нь олон улс даяар эдгээр асуудлыг авч үзэх шаардлагыг нөхцөлдүүлсэн. Тухайлбал, Их Британид 2011 онд “Шүүх шинжилгээний талаарх судалгаа, хөгжлийн асуудал” сэдвээр судалгаа хийгдсэн байна.²

Шүүх шинжилгээ нь талбарын шинжилгээ (хэргийн газрын шинжилгээ гэх мэт), лабораторийн шинжилгээ (ДНХ, хор судлал зэрэг), анагаахын шинжилгээ (патологи гэх мэт) гэсэн гурван төрөлд хуваагддаг олон салбар дамнасан, хоёрдмол шинжтэй шинжлэх ухаан юм. Эдгээр нь тус бүрдээ өөрийн судалгааны салбар, судлах зүйлтэй боловч бүхэлд нь цогц байдлаар авч үзэж шинжилгээг боломжит бүх талаас, иж бүрнээр хийхэд зохих үр дагаварт хүрдэгт тооцогддог. Ийнхүү шүүх шинжилгээ нь дотроо олон салбар бүхий цогц шинжлэх ухаан байдлаар хөгжиж байгаа бөгөөд энэ шинжлэх ухааны ололтыг хууль сахиулах, тэр тусмаа гэмт хэргийг илрүүлэн тогтооход өргөн ашигладаг цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бие даасан, төрийн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн харьяа шүүх шинжилгээний олон тооны судалгааны төв ажилладаг байдлаас харагдаж байна.

Институцийн хувьд шүүх шинжилгээний асуудлыг улсын хэмжээнд хариуцсан Шүүх шинжилгээний хүрээлэн ажиллах нь түгээмэл шийдэл бөгөөд эрдэм шинжилгээний ажлаас эхлээд захиргааны аппаратыг хүртэл чадмаг холбосон сайн зохион байгуулалттай энэхүү бүтэц нь улсын хэмжээнд шүүх шинжилгээний зохион байгуулалтын асуудлыг хариуцсан байгууллага байдаг. Санхүүжилтийн гол эх үүсвэр нь улсын төсөв бөгөөд үүнийг төлбөртэй

¹ Судалгаа нь Strengthening Forensic Science in the United States: A Path Forward нэртэй.

² Ross, Alastair, Forensic Science in Australia: Where does Australia sit in relation to Trends and Issues in the International Context?, Current Issues in Criminal Justice, Volume 24/No.1, p.121

үзүүлдэг үйлчилгээнээс олсон орлогоороо нэмэгдүүлэх боломжтой. Нөгөө талаас энэ салбарт төрийн байгууллага давамгайлдаг учраас төрийн монополь ноёрхох хандлагатай байна. Мөн ихэнх шүүх шинжилгээний төв, лабораториуд нь цагдаагийн байгууллагын дэргэд, түүний харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа нь цагдаагийн байгууллагаас хараат байдалтай болгох /бодит байдал дээр ийм байдалд хүргэж байгаа/ эрсдлийг бий болгодог. Ерөнхийдөө, зарчмын хувьд шүүх шинжилгээний байгууллагыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх дэд салбар бус бие даасан шинжлэх ухаан байдлаар авч үзэх хандлага тогтож байна гэж дүгнэж болох юм.

Шүүх шинжилгээгээр мэргэшсэн шинжээчийн хувьд шүүх шинжилгээний байгууллагад хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилладаг байнгын ажлын байр бүхий шүүхийн шинжээч ба шаардлагатай тохиолдолд тодорхой ажил гүйцэтгэх гэрээний дагуу хөлсөөр ажилладаг, эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад бүртгэгдэж, тодорхой хугацаатайгаар үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий гэрчилгээтэй, бие даасан мэргэжлийн шинжээч гэсэн 2 төрөл байна.

1.2 “Forensic science”-ийн тухай ойлголт

“Forensic science” нь гэмт хэргийн үйл ажиллагаанд оролцсон, түүнд холбогдсон хүн, газар, эд зүйлсийг тодорхойлох шинжлэх ухааны бие даасан нэг салбар бөгөөд энэ нь шинжлэх ухааны зарчмуудыг ашиглан эрүү, иргэн болон захиргааны хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаанд туслалцаа үзүүлдэг. “Forensic” гэдэг үг нь латин хэлний нийтэд зориулсан нээлттэй хэлэлцүүлэг, шүүх (forum) гэсэн үгнээс гаралтай. Илүү техник талаасаа “forensic” нь нээлттэй буюу эрх зүйн сэтгэл түгшээсэн асуудал гэсэн утгаар хэрэглэгддэг. Өнөөдөр “forensic science”-ийг хамтад нь тайлан, дүгнэлт, магадлагаа, мэдүүлгээр дамжуулан хэрэг, маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд магадлан нотлох шаардлагатай асуудалд хариулахаар ажилладаг мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын бүлгийг илэрхийлэхэд хэрэглэж байна.

“Forensic science”-ийн салбарууд

Криминалистик (criminalistic)	Криминалистик гэхэнэр томъёо нь зарим тохиолдолд forensic science-тай ижил утгаар хэрэглэгдэх тохиолдол бий. Криминалистик нь Герман хэлний kriminalistik гэх үгнээс Англи хэлэнд импортлогдсон бөгөөд эрх зүйн асуудлыг мөрдөн шалгах, түүнд шийдэл олох шинжлэх ухааны болон технологийн янз бүрийн аргуудыг илэрхийлдэг. Зарим шүүх шинжилгээний лабораторид шүүх шинжээчдийг криминалистикч гэж нэрлэж болдог. Үнэн хэрэгтээ криминалистик нь гэмт үйлдлийн дүнд бий болсон физикийн буюу биет нотлох баримтыг цуглуулах, шинжлэх үйлтэй холбогддог шүүх шинжилгээний нэг салбар юм. Үүнд: эм, мансууруулах бодис, галт зэвсэг, хэргийн газраас олдсон эд зүйл, хурууны хээ, цус, биеийн шингэн (нус, үрийн шингэн гэх зэрэг) болон бусад ул мөрт нотлох баримт хамаарна.
-------------------------------	---

Шүүх/Магадлах патологү(forensic pathology)	Сэжигтэй буюу үл мэдэгдэх нөхцөлд нас барсан тохиолдлын шалтгаан, байдлыг тодорхойлох чиг үүрэгтэй шинжилгээний ажилд клиникийн болон анатомийн патологийн чиглэлээр тусгайлан суралцсан анагаах ухааны мэргэжилтэн үүнд оролцоно. Энэ нь ихэнх тохиолдолд цогцост хийх задлан шинжилгээ буюу нас барсны дараах шинжилгээг хамарсан багийн ажил байна.
Шүүх/Магадлах хүн судлал(forensic anthropology)	Хүн болон түүний өвгийг судалдаг физикийн антропологийн нэг салбар юм. Шүүхийн хүн судлал нь хурууны хээ, фото зураг зэргээр дамжуулан хэн болох нь танигдахгүй байгаа хүнийг танихад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг.Шүүхийн хүн судлаачид нь ялангуяа бөмбөгдөлт, нисэх онгоцны сүйрэл зэрэг үй олныг хамарсан осолд өртсөн хохирогчдыг таних, таниулах зорилгоор бие эрхтнийг сэргээхэд гол үүрэг гүйцэтгэдэг.
Шүүхийн одонтологү(forensic odontology/forensic)	Сүйрэл, гамшгийн үеэр амь насаа алдсан хүний биенээс үлдсэн хэсгийг шинжлэх замаар тухайн хүнийг хэн болохыг тогтоодог. Гол төлөв хүний шүдийг нас барахаас өмнө болон дараах үетэй харьцуулах замаар шинжилгээ хийдэг байна.
Шүүх/Магадлах инженеринг(forensic engineering)	Тодорхой техник, эд зүйл, бүтээгдэхүүн, бүтэц нь зориулалтын дагуу ажиллахгүй байгаа тохиолдолд тэдгээрийн доголдлын шалтгаан, нөхцөлийг судлана. Ийнхүү зохих ёсоор ажиллахгүй байх нь иргэний эрх зүйн утгаараа эд хөрөнгөд хохирол учруулах магадлалтай бол эрүүгийн эрх зүйн тухайд зам тээврийн осол, нисэх онгоцны сүйрэлд хүргэж болзошгүй аюултай байх тул энэ төрлийн шинжилгээг хийх хэрэгцээ шаардлага үүсдэг байна.
Хор судлал(toxicology)	Хор, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис илрүүлэх зорилгоор биеийн шингэн болон эд, эст хийх химийн шинжилгээтэй холбогддог. Хор судлаачид нь хүний биед ямар нэгэн бодис байгаа тохиолдолд хэр их байгааг болон тэр нь ямар үр дагавартай байж болохыг тодорхойлно. Хамгийн түгээмэл жишээ нь цусан дахь согтоох бодисын түвшин, согтолтын зэргийг тодорхойлох явдал байдаг. ³

Үүнээс харахад forensic science-ийг явцуу утгаар нь авч үзвэлгэмт хэргийн ул мөрийг шинжлэн магадлах асуудал буюу криминалистик гэсэн ойлголттой дүйцүүлж болохуйц харагдах бөгөөд харин түүнийг өргөн хүрээнд тайлбарлавал криминалистикаас гадна олон

³ Max M.Houck, Jay A. Siegel, *Fundamentals of Forensic Science* (Second edition), 2009, pp.4-5

төрлийн тусгай шинжилгээний төрөл агуулсан, илүү өргөн хүрээний ойлголт байна. Иймд криминалистик нь энэхүү шинжлэх ухаанд хамаарах олон цогц ойлголтын зөвхөн нэг нь юм. Зарим улс оронд зөвхөн эхний агуулгаар ойлгодог бол зарим нь илүү өргөн утгаар хэрэглэдэг. Бидний энд сонгон судалж буй гадаад орнуудын дийлэнхи нь шүүх шинжилгээний институцийг өргөн хүрээнд авч үзэж байна.

1.3 “Police science”-ийн тухай ойлголт

“*Police science*” нь криминологи, шүүх шинжилгээ, психологи, хууль зүйн шинжлэх ухаан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа/процесс/, засан хүмүүжүүлэх, пенологи зэрэгтэй нягт холбоо хамааралтай судалгааны салбар юм. Тэр дундаа криминологи болон шүүн таслах ажиллагааны удирдлага (*the administration of justice*) судлал гэх хоёр салбар үүнтэй холбоотойгоор гол төлөв яригддаг.

Криминологи нь гэмт хэрэг болон түүнд үзүүлэх нийгмийн хариу үйлдлийг тайлбарлахад чиглэдэг. Нийгмийн шинжлэх ухаанд хамаарахын хувьд эхлээд гэмт этгээдийн зан үйлийг тайлбарлахыг оролдох ба дараагаар нь шүүн таслах ажиллагаа болон бусад тогтолцоо гэмт хэрэгт хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг судалдаг. 1980-аад оны эхэн үеэс хойш криминологийн судалгаа нь цагдаагийн судалгааны салбартай мэдэгдэхүйц давхцах болсон нь ажиглагдаж эхэлсэн бөгөөд энэ байдал өнөө хэр үргэлжилж байна гэж үздэг. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдлага судлал нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа/процессийн ажиллагаа/-г хариуцдаг институци нь гэмт хэрэгтэн, хохирогч, олон нийтэд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгаад анхаарлаа хандуулдаг.

Сүүлийн жилүүдэд “*police science*” гэх ойлголтыг криминологи болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдлагын аль алинд хамаарах агуулгаар авч үзэж байна. Криминологийн үүднээс авч үзвэл “*police science*” нь “юуны учир мөрдөх, шалгах вэ” гэх асуултыг ойлгоход чиглэсэн хувь хүн, бүлэг, нийгэм, институцийг хамарсан өргөн хүрээний онолын талбар болж байгаа бол шүүн таслах ажиллагааны удирдлагын тухайд илүү сайн системтэй, шинжлэх ухаанч үнэлгээний судалгаа хийх замаар нотлох баримтын үйлчлэл болон бодлогын судалгааны үүднээс хандах асуудлыг онцолдог. Эдгээр хандлагыг нэгтгэснээр “*police science*”-ыг цагдан шалгах ажиллагаа ямар шалтгааны улмаас байх шаардлагатай, түүнийг юу бүрдүүлдэг, нийгмийн янз бүрийн орчинд хэрхэн тохируулан ажиллуулах, цагдаагийн институцийн үйл ажиллагаанд нийгэм, улс төрийн үнэт зүйлийг хэрхэн тусгах, ямар онолыг мөрдөх, шалгах ажиллагааны үндэс болгох, цагдаагийн шинэчлэлийг хэрхэн хийх, түүний үр нөлөө ямар байх талаарх асуудлуудыг цогц байдлаар судалдаг гэж үзэх болсон байна.⁴

2 МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ

2.1 Түүхэн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал

Түүхэн хөгжил

Монголчууд эртнээс өргөн уудам нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэн нүүдэлчин соёл иргэншилээр амьдарч ирсэн үндэстэн юм. Өнөөг хүртэл хадгалж үлдсэн нүүдэлчин соёлоос харахад манай ард түмний аливаа зүйлийг танин мэдэх, учир шалтгааныг тунгаан бодох, адилтган харьцуулах ухаан нь, мал аж ахуйтай салшгүй холбоотой байдаг. Тухайлбал адуу

⁴Энэ талаар дэлгэрэнгүйг Jack R. Greene (ed.), *The Encyclopedia of Police Science* (Third edition): Volume 1 A-I index, 2006, p.xix-аас дэлгэрүүлж үзнэ үү.

малдаа тамга, тэмдэг тавих нь нэг төрлийн тоо бүртгэл хөтлөх, хулгай дээрэм, оргодол олохдоо халуун мөрөөр нь мөшгих, эрэл сураг гаргахзэрэг мөрдөн шалгах ажиллагааны аргыг эртнээс эхлээд өнөөг хүртэл хэдэн зуун жил хэрэглэж ирсэн байдаг. Мөн аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээхүний амь нас хохирсон бол эмч, оточ, бичгийн хэвийг эрдэм боловсролтой бичгийн хүнээр магадлуулах, малын мөрийг малч хүнээр, галт зэвсгийн хэрэг гарвал буу зэвсэг сайн мэддэг хүнээр шинжлүүлэх нь ач холбогдолтой гэж үздэг байсан нь тухайн үед хэрэг маргаан шийдвэрлэхдээ мэргэжлийн шинжээчдийг татан оролцуулдаг уламжлалтай байсныг харуулж байна⁵.

Шүүх шинжилгээний үйл ажиллагаа ба эрх зүйн орчны хөгжил

Монголчууд Хүннүгийн үеэс эхлэн хууль цаазад захирагдан ирсэн гэж үздэг. Үүний тод жишээ болох “Их Засаг” хэмээх хууль цаазад “*зандалчилан гүвшилцэх, хулгай дээрэм хийх, хүн алах, шархдуулах, архидан согтуурах*” зэрэг эрүүгийн хуулийн холбогдолтой 40 гаруй заалт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой 8 заалт байсан гэж судлаачид үздэг. Үүнээс харахад тэр үед гэмтлийн зэргийг их нанчих, дунд нанчих, бага нанчих гэж 3 зэрэг болгон тогтоосон байдаг нь өнөөг хүртэл шүүх шинжилгээнд хэрэглэгдэж байгаа юм. Үе үеийн хууль цаазад шүүх шинжилгээтэй холбоотой зохицуулалт орсон байдаг. Тухайлбал “Халх журам”, “Гурван хошууны хуульчилсан бичиг” зэрэг хууль цаазын дурсгалт бичигт хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох болон түүнийг баталгаажуулах аргын тухай заасан байдаг бол XIX зууны эхэн үед тоо бүртгэлийн тогтолцоо үүссэн байсны тод жишээг 1820-1913 оны хооронд хөтөлж байсан бүртгэл болох “Улаан хацарт”, “Хугархай нүүрт” гэх данс бүртгэл харуулж байна⁶.

Монгол Улсад Үндэсний эрх чөлөөний тэмцлийн үр дүнд анх 5 яам бүхий Түр Засгийн газрыг байгуулснаар хууль тогтоомж боловсруулах, хэвлэн нийтлэх ажил эхэлсэн түүхтэй бөгөөд үүнээс хойш боловсруулсан хууль тогтоомжид 1919-өөд оны Зөвлөлт Орос Улсын эрүүгийн эрх зүйн үндэс болон туршлагыг судалж үлгэрчлэх, зарим нэг хуулийг шууд хуулбарлан хэрэглэсэн байдаг. Харамсалтай нь эдгээр хууль тогтоомж нь үндсэндээ шүүх шинжилгээний хэрэгцээ шаардлагыг үгүйсгэсэн, зөвхөн сэжигтэн болон гэрчийн мэдүүлэгт үндэслэн яллах боломж олгож байсныг хожимхэлмэгдүүлэлтийн үед Вышинскийн зарчим буюу “Хэргээ өөрөө хүлээх нь хамгийн дээд зэргийн нотолгоо мөн” зарчмаар зөвхөн улс төрийн хэрэг төдийгүй бараг бүх төрлийн хэрэг маргааныг шинжлэх ухааны аргаар нотлох аргыг үгүйсгэн, хэрэглэхгүйгээр шийдвэрлэж байсан жишээнээс харж болох юм.

Монгол Улс дахь шүүх шинжилгээний байгууллагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон, орчин цагийн анхны эрх зүйн баримт бичиг болох “Монгол Улсын Шүүх Таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай” хуулийг 1926 онд⁷ баталсан нь шүүх шинжилгээний жинхэнэ эрх зүйн үндэс болсон гэж үздэг байна. Уг хуулийн 18-р зүйлд “*хэрэгт ноцогдсон буюу хэрэг тохиосон этгээдээс гэрч ба жич эксперт хэмээх хэргийн учрыг шинжлэн мэдэх хүмүүсээс гуйх*”⁸ гэж заасан явдал нь гэмт хэргийн шинжлэх ухааны үүднээс нотлох, үүнд мэргэшсэн хүмүүсийг татан оролцуулах шаардлагыг харуулсан чухал заалт байсан хэдий ч огт хэрэгжээгүй юм. Учир нь XX зууны эхэн үеэс 1960-аад он хүртэлх хугацаанд Монголын нийгмийн байдал тогтворгүй, дайн байлдаан, бослого хөдөлгөөн ихтэй,

⁵“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 22-р тал

⁶Н.Зоригт, Г.Мөнхбат, Т.Баатар “Шүүх эмнэлэг” УБ. 1999 он. 6-р тал.

⁷<http://www.ama.org.mn/History/>сүүлд үзсэн огноо: 2015.05.25/

⁸С.Бадарчи “Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистикийн арга хэрэгслийг хэрэглэж байгаа нь” УБ. 1993 он. 9-р тал.

коммунист нийгэм байгуулах мөрөөдөлд хөтлөгдсөн он жилүүд байсан нь аливаа хэргийг шүүх шинжилгээний аргаар нотлох орчин нөхцөл бүрэлдэхгүй байсантай холбоотой юм⁹.

Шүүх шинжилгээний тусгай мэдлэгийн хөгжил

Манай улсад 1920-оод оноос эхлэн шүүх шинжилгээний тусгай мэдлэг шаардсан шинжилгээг хийж эхэлсэн гэж үздэг. Тухайлбал 1923 онд БНМАУ-ын Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатарын цогцост Орос-Монголын хамтарсан тусгай комисс шүүх шинжилгээ хийснийг Монголын түүхэн дэх анхны шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ гэж үздэг байна¹⁰. Харин бичиг судлалын шинжилгээ буюу одоогийн баримт бичгийн шинжилгээг 1930-аад оноос эхлэн тухайн үеийн хэл бичгийн эрдэмтэд Д.Нацагдорж, Я.Цэвэл болон Д.Донров нараар гүйцэтгүүлдэг байсан байна¹¹. Дээрх хоёр шинжилгээнээс гадна галт зэвсгийн шинжилгээг тусгай мэдлэг бүхий шинжээчийн оролцоотойгоор гүйцэтгэдэг байсан нь манай улсад шүүх шинжилгээ үүсэн хөгжих эхлэл болсон гэж үзэж болох юм. Шинжлэх ухааны дэвшилт болсон гэрэлзургийг эд мөрийн баримт баталгаажуулах ажилд Монголчууд 1928 оноос ашиглаж ирсэн бөгөөд түүний ач холбогдол нэмэгдэхийн хэрээр хууль тогтоомж болон Дотоодыг Хамгаалах Газрын /цаашид ДХГ гэх/ тушаалаар энэ аргаар ул мөр баталгаажуулах нотлох баримтын хүрээг улам өргөжүүлж иржээ¹². Гарын хээ шинжлэл нь манай улсад 1937 онд тухайн үеийн Цагдан сэргийлэх газрын харьяа Гүйцэтгэх тасагт “хурууны хээ шинжлэгч” буюу гарын хээний шинжээчийн орон тоо бий болгосноор эхлэлээ олсон юм¹³.

Орчин цагийн шүүх шинжилгээний байгууллагын үүсэл, хөгжил

Аливаа улс орны нийгэм, эдийн засгийн байдал тухайн оронд гарч буй гэмт хэргийн гаралтын өсөлт, бууралт, түүнийг үйлдэж буй арга хэлбэрийн өөрчлөлттэй салшгүй холбоотой байдаг. Ялангуяа дайн, эмх замбараагүй байдал, ядуурал зэрэг нийгмийн сөрөг үйлдлийн үр дагаварт гэмт хэргийн тоо үлэмж хэмжээгээр өсдөг бөгөөд түүнийг үйлдэж буй гэмт этгээдүүдийн үйлдэл цаг үеэ даган улам шинэлэг, боловсронгуй болж байдаг. Энэ нь өнөөгийн техник, технологийн хөгжлийн эрин үед улам нарийн арга, /далд/ хэлбэрт шилжихээс гадна шинэ төрлийн гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа тул шүүх шинжилгээ хийж буй шинжээчдийн мэдлэг, ур чадвар, ашиглаж буй техник технологи, тоног төхөөрөмжийн боловсронгуй байдлыг хангаж ажиллах нь нийгмийн шаардлага болж байна. Ингээд манай улсын шүүх шинжилгээний байгууллагын үүсэл, түүхэн хөгжлийн талаар товч авч үзье.

Монгол Улсад 1944онд Дотоод явдлын яамны Сайдын /цаашид ДЯЯСайд гэх/ 14 тоот тушаалаар анхЦагдан сэргийлэх газрын Гүйцэтгэх хэлтэст /цаашид ЦСГГХ гэх/- “Шинжлэн магадлах техникийн тасаг” буюу Дөрөвдүгээр тасгийгшүүх шинжилгээ хийх үүрэг бүхий 9 хүний орон тоотойгоор байгуулсан нь криминалистикийн шинжилгээний байгууллагын үндэс суурь болсон гэж албан ёсоор үздэг байна¹⁴. Ийнхүү криминалистикийн техникийн үндсэн гурван төрөл болох хурууны хээ, гэрэл зураг, тоо бүртгэлийн шинжилгээг нэгтгэх үндсэн шалтгаан нь шинэ төрлийн гэмт хэргийн тоо өссөн, гэмт хэрэг үйлдэх арга барил өөрчлөгдөж байгаа, гэмт хэргийн ул мөрд шүүх шинжилгээ хийх чадвартай мэргэжилтнүүдийн залгамж үе бэлтгэгдэж эхэлсэн, мөн эдгээр тусгай мэдлэг бүхий шинжээчдийг нэгдсэн улирдлагаар хангаж ажиллах болон тэдний харилцаа холбоо, мэдээллийн солилцоог сайжруулах хэрэгцээ

⁹“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 29-р тал.

¹⁰Н.Зоригт, Г.Мөнхбат, Т.Баатар “Хагас зууны хөгжлийн түүх” УБ. 2010 он. 11-р тал.

¹¹“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 23-р тал.

¹²С.Бадарчи “Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистикийн арга хэрэгслийг хэрэглэж байгаа нь” УБ. 1993 он. 24-р тал.

¹³“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 23-р тал.

¹⁴“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 33-р тал.

шаардлага үүссэн явдал юм. Иймд тусгай нэгж байгуулан шүүх шинжилгээний чиг үүрэг бүхий албан хаагчдыг харъяалуулж тэднийг шинжлэх ухаанч арга зүйгээр хангаж ажиллахад ач холбогдол өгсөн шийдвэр гэж үздэг. Үүнээс харахад шүүх шинжилгээний чиглэлээр ажиллаж буй шинжээчид анх ЦСГ-ын харьяаны алба хаагчдаас бүрдэж байсан учир тэдэнд цагдаагийн алба хаагчийн нэгэн адил цол¹⁵ олгодог уламжлал тогтож өнөөг хүртэл хэрэгжиж байна гэж үзэж болох юм.

Ийнхүү эхлэлээ олсон шүүх шинжилгээний байгууллагын хөгжилд МАХН-ын Төв хорооны Улс Төрийн Товчоо/цаашид ТХУТТовчоо гэх/ 1957 оны “Цагдан сэргийлэх байгууллагын ажлын тухай” 19-р тогтоол гарсан явдал нь криминалистикийн техникийн салбарыг хөгжүүлэх гол удирдамж болсон байна. Үүний дараа ЦБНАХХЭЯ-ны сайдын “Цагдан сэргийлэх газрын ажиллагаанд шинжлэх ухаан техникийн арга хэрэглүүрийг нэвтрүүлэх ажлыг сайжруулах тухай” 600 тоот тушаал гарч 1958 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн “Шинжлэх ухаан техникийн тасаг”-ийг /цаашид ШУТТ гэх/ 7 орон тоотойгоор байгуулж, дүрмийг баталснаар Монгол Улсад орчин цагийн шүүх шинжилгээний байгууллага үүссэн гэж үздэг¹⁶. Мөн 1959 онд НАХЯамны сайдын 809 тоот тушаалаар УЦСГХ-ийн бүрэлдэхүүнд байсан ШУТТ-г УЦСГ-ын дэргэдэх тусгай тасаг болгосноор статус дээшилсэн төдийгүй гүйцэтгэх үүрэг даалгавар, хариуцлагын хэмжээ нэмэгдсэн юм. Үүний дараа төд удалгүй криминалистикийн олон төрлийн шинжилгээ хийх чадвартай болсон ШУТТ-г 1963 оны 1 сарын 1-нээс эхлэн УЦСЕГ-ын Криминалистикийн хэлтэс болж өргөжүүлсэн бөгөөд энэ хэлбэрээр 40 гаруй жил үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Нийгмийн хөгжил, цаг үеийн шаардлага, үүн дотроо Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулийн дагуугамт хэргийн нотлох баримтыг шинжлэх ухааны болон техник, технологийн ололт ашиглан илрүүлж нотлох шаардлага улам өндөржихийн зэрэгцээ дэлхий нийтийн хөгжил болон дотоодод шинээр үүсэн бий болж байгаа нөхцөл бололцоонд нийцсэн, мэргэжлийн ур чадвартай мэргэжилтнүүдийн баг бүрдүүлж тэднийг тоног төхөөрөмж, материаллаг баазаар хангахын тулд тухайн үеийн төрөөс багагүй хүчин чармайлт гаргаж, асуудлыг шийдвэрлэж ажиллаж байжээ. Энэхүү хичээл зүтгэлийн тод харуулах дараах шийдвэрүүд ар араасаа гарч байсан юм. Тухайлбал 1974 оны СнЗөвлөлийн тогтоолын¹⁷ дагуу ШУТХ-т хими, физик, биологийн шинжээчийн орон тоо бий болгосон ба мөн онд УЦСЕГ-ын хими, физик, биологийн лаборатори байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах тухай тогтоол¹⁸ гаргасан байдаг. Дээрхи шийдвэрүүд ажил хэрэг болж 1978 онд тус лаборатори нээгдсэнээр криминалистикийн шинжилгээгээр магадлах асуудлын хүрээ улам тэлсэн бөгөөд бодисын бүтэц, найрлага, цусан дахь согтууруулах ундааны хэмжээ, хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартыг шалгах, хэргийн газраас олдсон биологийн гаралтай баримтыг шинжлэх зэрэг олон төрлийн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх бололцоотой болжээ. Мөн тус салбарын техник хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлэх, хангамжийг сайжруулахад НАХЯ-ны сайдын¹⁹ УЦСЕГ-т ашиглагдаж байсан техник хэрэгслийг ШУТХ-т шилжүүлэх тухай шийдвэр чухал ач холбогдолтой байсан юм²⁰. Шинэ лаборатори, шинэ шинжилгээний ажилд 1975 оноос эхлэн ЗХУ-д мэргэжил эзэмшсэн криминалистикийн

¹⁵1936 оноос Боловсронгуй хамгаалагч, Хичээнгүй энхжүүлэгч, Тохижуулагч, 1940 оноос Бага лейтанант, Лейтанант, Ахлах лейтанант, 1944 оноос хойш өнөөг хүртэл хэрэглэгдэж буй Ахлагч, Ахмад, Хошуучаас Генерал хүртэлх цол олгодог байжээ.

¹⁶“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 29, 38-р тал.

¹⁷БНМАУ-ын СнЗөвлөлийн 1974 оны 1 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоол

¹⁸БНМАУ-ын СнЗөвлөлийн 1974 оны 12 сарын 27-ны өдрийн 559 дүгээр тогтоол

¹⁹НАХЯ-ны сайдын 1981 оны 3 сарын 16-ны өдрийн 20 дугаар тушаал

²⁰Ч.Алтанхишиг “Нэгэн жаран” УБ. 2004 он. 39-р тал.

шинжээчдийн зэрэгцээ байгаль, техникийн шинжлэх ухааны чиглэлээр дээд боловсрол, мэргэжил эзэмшсэн боловсон хүчин ШУТХ-т ажиллах болсон байна.

Техник, технологи, боловсон хүчний хувьд харьцангуй чадавхижсан ШУТХ-ийн дүрмийг 1987 онд²¹ шинэчлэн баталсан бөгөөдүг дүрэмд “Криминалистикийн шинжилгээний төв нь цагдаагийн байгууллагын бусад албад, хууль хамгаалах байгууллагуудтай хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг зохион байгуулахад идэвхитэй оролцохын зэрэгцээ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагын шийдвэрийн дагуу мөр судлал, бичиг техник, гарын үсэг, галт зэвсэг, хүний гадаад төрхөөр нь адилтгах, хими, физик, биологийн зэрэг шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт, магадлагаа гаргах, гэмт хэрэг учралын газарт криминалист мэргэжилтнээр оролцож, түүнийг шийдвэрлэхэд ач холбогдолтой эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хураан авах ажиллагааг хийх үүрэгтэй”²² гэж заасан нь шүүх шинжилгээний байгууллагын албан хаагчдын гэмт хэргээс сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх ажилд мэргэжлийн дагуу хүлээх үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлсэн төдийгүй шүүх шинжилгээний байгууллагын шинжлэх ухааны зарчимд тулгуурлан гаргасан дүгнэлт, магадлагааг хүлээн зөвшөөрөх тухайд чухал нөлөө үзүүлсэн шийдвэр болсон.

1980-аад оны дунд үеэсэхэлсэн нийгэм, эдийн засгийн тогтолцооны шилжилтийн үйл явцын үр дүнд Монгол Улсад улс төр, нийгэм, эдийн засгийн суурь бүхэлдээ өөрчлөгдсөн бөгөөд үүнтэй холбоотойгоор төрийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх процесс эхэлсэн юм. Судалгааны ажлын хүрээнд авч хэлэлцэж буй шүүх шинжилгээний чиг үүрэг бүхий байгууллагын бүтэц зохион байгуулалтад шууд нөлөөлсөн НАХЯ болон түүний харьяа агентлагуудын тухайд өрнөсөн өөрчлөлтийг товч авч үзье.

1990 онд БНМАУ-ын НАХЯ-ыг татан буулгасан ба түүний харьяанд үйл ажиллагаа явуулж байсан албадууд задарч ЗГ болон бусад яамдад харьяалагдах болсон. Тухайлбал Цагдан сэргийлэх байгууллага бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлтөд орсон ба Цагдаагийн Ерөнхий Газар /цаашид ЦЕГ гэх/ нэртэйгээр бие даасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага болон шинэчлэгдсэн. Мөн 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаар хууль тогтоомжийг түүний үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэх шаардлага үүссэн бөгөөд энэхүү эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 1993 онд “Цагдаагийн байгууллагын тухай” хуулийг баталсан. Уг хуульд цагдаагийн төв байгууллагын харьяанд 6 алба, 6 төв ажиллахаар заасан байсны нэг нь Криминалистикийн шинжилгээний төв /цаашид КШТ гэх/ байжээ. Нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал, ажилгүйдэл, ядуурал ихэсхийн хэрээр гэмт хэргийн төрөл, тоо огцом өсөж байсан энэ үед шүүх шинжилгээний байгууллагын бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний хувьд ч мөн адил тогтворгүй байсан үе юм. КШТ-д ажиллаж байсан мэргэшсэн боловсон хүчин, шинжээчид зах зээлийн нийгэмд шилжсэн улс орны эдийн засгийн хүнд нөхцөлд ажил мэргэжлээ орхин хувиараа хөдөлмөр эрхлэх болсон, шинэ мэргэжилтэн бэлтгэх ажил орхигдсонтой холбогдуулан хүний нөөцийн хомсдол үүсч энэ доголдлоос гарах үйл хэрэг 20 орчим жил үргэлжилсэн юм.

2.2 Шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт

Нийгэм, эдийн засгийн тогтолцооны шилжилтын үед шүүх шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоонд цөөнгүй удаа өөрчлөлт оруулж байсан бөгөөд эдгээр өөрчлөлтүүд нь байнга тухайн байгууллагын үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулахад чиглэгдсэн байсан.

²¹НАХЯ-ны нэгдүгээр орлогч сайд, 1987 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/10 дугаар тушаал

²²“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 29, 63-р тал.

Тухайлбал 1993 онд ЦЕГ-ын даргын тушаалаар²³ КШТ-ийн орон тоог шинэчлэн, нийт 34 алба хаагчтай байхаар баталсны²⁴ 20 орчим нь мэргэшсэн шинжээч байсан байна. Үүнээс хойш 1998 онд бүтцийн өөрчлөлт²⁵ хийснээр КШТ лабораторийн системд шилжих эхлэл тавигдсан бөгөөд гарын мөрний болон тусгай шинжилгээний лабораториуд бие даасан нэгжийн зохион байгуулалтад орсон бол 1999 онд дахин бүтцийн өөрчлөлт хийж албаны нохойн тасгийг КШТ-д шилжүүлсэн, ахлах нягтлан бодогч, техникийн байцаагч, няравын орон тоо бүхий бие даасан санхүүтэй болгосон байна. Үүний зэрэгцээ дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн дэргэд шинжилгээний болонадилтгалын лабораториудыг байгуулж эхэлсэн²⁶ байдаг.

Манай орны хувьд шүүх шинжилгээ хийж магадлагаа, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий бүтэц байнга ЦСГ-ын аль нэг газар, хэлтэс, хэсэг, тасагт харьяалагдан ажиллаж байсныг судалгааны ажлын өмнөх хэсгээс харж болно. Мэргэжлийн түвшинд харьцангуй хараат бус, бие даасан, тодорхой чиглэлээр дагнан мэргэшсэн шинжээчид КШТ болсон үеэс эхлэнүйл ажиллагааг явуулсан гэж үзэж болохоор байна. Шүүх шинжилгээний үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан үе үеийн цагдаагийн байгууллагын удирдлага шинжлэх ухааны онол, зарчимд суурилсан шүүх шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагын дагуу өөрсдийн нөхцөл бололцооны хүрээнд энэ чиглэлээр ажиллах боловсон хүчний тоог нэмэх, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг улсын хөрөнгөөр зохион байгуулсаар иржээ. Тухайлбал УЦСЕГ-ын ШУТХ-ийн тухайн үеийн шинжээчид бүх төрлийн шинжилгээг хийдэг байсан бол тодорхой чиглэлээр мэргэшүүлэх, дагнасан шинжилгээ хийх техник технологийн болон боловсон хүчний нөхцөл зөвхөн 1990-ээд оноос эхлэн бүрэлдсэн гэж үзэж болно.

Шилжилтийн үеийн дараах жилүүдэд шүүх шинжилгээний байгууллагын хувьд цаг үетэй нийцсэн шинэ тоног төхөөрөмж ашиглах, боловсон хүчнээ шинэ мэдлэг туршлага олгох замаар ур чадварыг нь тогтмол дээшлүүлэх шаардлага байнга гардаг байв. Техник, технологийн шинэчлэлийг цаг үеийн хөгжилтэйгээ нийцүүлэн өөрийн нөөц бололцооны түвшинд, олон улсын байгууллагын тусламжаар болон гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд сайжруулсаар ирсний жишээ нь гарын хээг автоматаар харьцуулах “Папилон” системийг ашиглах, галт зэвсгийн хонгио, хошууны сан бүрдүүлэх, автоматаар харьцуулах шинжилгээний ажилдаа 1991 онд анх компьютер хэрэглэж эхэлсэн явдал юм. Харин улс төр, нийгэм, эдийн засгийн байдлаас хамааран төсөв, санхүү хүрэлцэхгүйгээс зөвхөн өдөр тутмын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай зүйлдээ хөрөнгө, санхүү гаргах боломжтой энэ байгууллага нь томоохон хэмжээний тоног төхөөрөмжийн шинэчлэл болон боловсон хүчний чадавхиа дээшлүүлэх зэрэг өөрчлөлт, шинэчлэлийг гадаадын болон олон улсын донор байгууллагатай хамтран эсхүл тэдний тусламжаар хэрэгжүүлдэг хэвээр байна. Тухайлбал мэргэжлийн шинжээчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд БНХАУ, ӨМӨЗО, Япон, ОХУ, Энэтхэг, Солонгос зэрэг орнуудын шинжилгээний албадтай харилцаа хамтын ажиллагаатай ажиллаж, харилцан туршлага солилцох ажил ач холбогдолтой юм. Тус орнуудад ажиллаж буй шинжээчид гарын хээний “Адис-Папилон”, галт зэвсгийн “Абис-Арзенал” ашиглах, түүнд мэдээлэл оруулах, хар тамхи, мансууруулах бодис шинжлэн тогтоох, ДНХ-ийн шинжилгээний чиглэлээр болон бусад сэдвээр туршлага судалдаг. Шинжилгээний лабораториудыг шинэчлэх, тоног төхөөрөмжийн инноваци хийхэд ХБНГУ, АНУ, Франц, НҮБ-ын хөгжлийн сан зэрэг хандивлагч орон, олон улсын байгууллагын оролцоо их байдаг.

Өнөөгийн шүүх шинжилгээний байгууллага

²³ЦЕГ-ын даргын 1993 оны 5 сарын 27-ны өдрийн 128 тоот тушаал.

²⁴ЦЕГ даргын 1993 оны 5 сарын 27-ны өдрийн 128 тоот тушаал.

²⁵ЦЕГ даргын 1998 оны а/23 тоот тушаал

²⁶ЦЕГ-ын даргын 1998 оны а/77 тоот тушаал

Монгол Улсад шүүх шинжилгээний байгууллагын нэгдсэн тогтолцоо бий болох үйл явц 1998 онд “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр²⁷” батлагдсанаар эхэлсэн юм. Уг хөтөлбөрийн дагуу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд магадлагаа, дүгнэлт гаргадаг байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулах, харилцаа холбоог сайжруулах арга хэмжээ авах үүргийг ХЗЯ, ЦЕГ-т хариуцуулсан бөгөөд үүний мөрөөр хэрэгжүүлсэн ажлын нэг нь ЦЕГ-ын дэргэдэх КШТ-ийг Шинжилгээний хүрээлэн²⁸ болгон өргөтгөж, бүтэц орон тоог шинэчлэн баталж өөрчилсөн явдал юм.

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан санаа 2005 онд Шүүхийн шинжилгээний үндэсний төв, 2009 оноос Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнг байгуулснаар²⁹ хэрэгжсэн гэж үзэж болох юм. Тус төвийг байгуулахдаа ЭМЯ-ны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, ЦЕГ-ын Шинжилгээний хүрээлэнг тус тус нэгтгэсэн байна. Бие даан үйл ажиллагаа явуулж байсан шинжилгээний албадыг нэгтгэн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулах, үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боловсон хүчний тоо, чадавхийг нэмэгдүүлэх³⁰ зэрэг томоохон зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүний үр дүнд өөр өөрийн чиглэлээр ажиллаж дадсан бие даасан гурван байгууллагын үйл ажиллагааг нэг удирдлагад оруулсан юм. Энэ ажлын хүрээнд гаргасан Засгийн газрын “Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай³¹” 2007 оны тогтоолоор аймгийн цагдаагийн газар, криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн эмнэлгийн шүүх шинжээч эмч нарыг нэгтгэн аймгийн шинжилгээний алба байгуулах асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд 2009 оны 1 сараас албадыг байгуулах ажлаар үргэлжилсэн юм.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалт



2005 оноос улсын хэмжээнд шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулж буй улсын төсвөөс санхүүждэг төрийн байгууллага болох ХЗЯ-ны харьяа Шүүхийн шинжилгээний

²⁷УИХ-ын 1998 оны 18-р тогтоолын 44-р зүйл

²⁸ЦЕГ-ын даргын 2003 оны 286 дугаар тушаал

²⁹ЗГ-ын 2005 оны 3 сарын 23-ны өдрийн 63-р тогтоол

³⁰ХЗДХ-ийн сайдын 2005 оны 5 сарын 10-ны өдрийн 72 тоот тушаал

³¹Засгийн газрын 2007 оны 270 дугаар тогтоол

үндэсний хүрээлэн /цаашид ШШҮХ гэх/нь Криминалистикийн шинжилгээний хэлтэс³², Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс³³, Тусгай шинжилгээний хэлтэс³⁴, Эдийн засгийн шинжилгээний хэлтэс³⁵, Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс³⁶, Стратеги, хөгжлийн бодлогын хэлтэс³⁷, Хангамж, техникийн үйлчилгээний хэлтэс³⁸, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар³⁹ гэсэн 8 хэлтэс, газартай 20 орчим шинжилгээний лаборатори, 520 орчим ажилтан, алба хаагчтай томоохон бүтэц болон өргөжин хөгжсөн байна. Үүнээс зарим нэгжийн үйл ажиллагааг онцолъё. Үүнд: Тусгай шинжилгээний хэлтэс 1978 онд анх хими, физик, биологийн лабораториудыг байгуулж байгалийн шинжлэх ухааны ололтыг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглаж эхэлсэн байна. Эдгээр тусгай шинжилгээний лабораториуд нь Шүүх эмнэлгийн хэлтсийн лабораториудтай нэгдсэнээр Шинжилгээний лабораторийн хэлтэс⁴⁰ болсон бөгөөд 2013 оноос эхлэн Тусгай шинжилгээний хэлтэс⁴¹ болж 21 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж биологи, ДНХ, бактерлоги, хими, физик, биологи, генетик, хүний эмчийн мэргэжилтэй алба хаагчид ажиллаж дүгнэлт гаргаж байна. Криминалистикийн шинжилгээний хэлтэст мөр судлал, гарын мөр, галт зэвсэг, баримт бичиг, гэрэл зураг, дүр зураг, дүрс бичлэг, автотехникийн шинжилгээний лабораториуд эрүү, иргэний болон захиргааны хэрэгт эрх бүхий байгууллага, этгээдийн томилсон тогтоол, захирамжийн дагуу криминалистикийн 11 төрлийн оношлох, адилтгах шинжилгээг орчиг үеийн техник тоног төхөөрөмж ашиглан, шинжилгээний арга аргачлал, стандартын дагуу тусгай мэдлэг, хуулийн хүрээнд хийж дүгнэлт гаргадаг. Шүүх эмнэлэг: Манай иргэдийн дийлэнхи хувь шүүх шинжилгээг шүүх эмнэлэгтэй шууд холбож ойлгох нь түгээмэл асуудал юм. Учир нь шүүх шинжилгээний хэлбэрүүдийн дундаас иргэдтэй хамгийн олон тохиолдлоор шууд харилцдаг хэлбэр нь шүүх эмнэлгийн шинжилгээ буюу гэмтлийн зэрэг тогтоох, задлан шинжилгээ хийх зэрэг юм. Манай улсад анх 1960 онд БНМАУ-ын СнЗ-ийн 198 дугаар тогтоолоор ЭМЯ-ны харьяанд Шүүх эмнэлгийн магадлах товчоог⁴² байгуулж 1963 онд “Шүүх эмнэлэг, задлан

³²Тус хэлтэст Мөр судлалын шинжилгээний лаборатори, Гарын мөрийн шинжилгээний тасаг, Бичиг баримтын шинжилгээний лаборатори, Галт зэвсгийн шинжилгээний лаборатори харьяалагдаж байна.

³³Тус хэлтэс Хүний биед хийх шинжилгээ, Цогцост хийх шинжилгээ, Дүрс оношлогооны шинжилгээ, Эд, эсийн шинжилгээний лаборатори, Хэргийн материалаар хийх шинжилгээ харьяалагдаж байна.

³⁴Биологийн шинжилгээний лаборатори, ДНХ-ийн шинжилгээний лаборатори, Бактериологийн шинжилгээний лаборатори, Химийн шинжилгээний лаборатори, Физикийн шинжилгээний лаборатори харьяалагдаж байна.

³⁵2005 оноос хойш ШШҮТөвийн харьяанд ажиллаж 2009 оноос эхлэн хэлтэс болон шүүх-эдийн засгийн шинжилгээ хийж дүгнэлт гаргаж байна.

³⁶ХЗСайдын 2013 оны 1 сарын 11-ний өдрийн А/04 тоот тушаалаар байгуулагдсан тус хэлтэс Шинжилгээний бүртгэл, Шинжилгээний объектын бүрэн бүтэн байдлыг хангах, Лавлагаа, мэдээлэл, Архив, Статистик, Танигдаагүй, хариуцах эзэнгүй цогцос таниулах, оршуулах ажлын хариуцан ажилладаг.

³⁷ХЗДХСайдын 2008 оны 164, 165 тоот тушаалаар байгуулагдсан Санхүү, төлөвлөлтийн тасаг³⁷ 2008 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүтэц, орон тоог нь 2011, 2013 онд ХЗсайдын тушаалаар тус тус өөрчилсөн байдаг.

³⁸Хангамж, техникийн үйлчилгээний хэлтэс нь 2005 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2009, 2013 онд тус тус ХЗСайдын тушаалаар бүтэц, орон тоог өөрчлөн нэмснээр одоо 33 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

³⁹ХЗСайдын 2013 оны 1 сарын 11-ний өдрийн А/04 тоот тушаалаар шинээр байгуулагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь алба хаагчдын сахилга, ёс зүй, үйл хжиллагааны чанарт хяналт тавьж ажилладаг.

⁴⁰ХЗДХЯ-ны сайдын 2011 оны 3 сарын 10-ны өдрийн 43 тоот тушаал

⁴¹2013 оны 1 сарын 11-ний өдрийн Б/01 тоот тушаал

⁴²1965 оны 5 сарын 12-нд БНМАУ-ын СнЗ-ийн 157 дугаар тогтоолоор УШЭМТовчооны дүрмийг баталсан.

шинжилгээний албан ажлын ерөнхий заавар⁴³-ыг баталж байжээ. Энэ шинжилгээний заавар нь цогцост задлан шинжилгээ хийх анхны хууль эрх зүйн бие даасан баримт бичиг болсноороо онцлог юм. Шүүх эмнэлэг 1960 онд 7 орон тоотой, 1979 онд 28 орон тоотой байсан бол өнөөдөр 45 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд 2013 оны статистик мэдээнээс⁴⁴ харахад шүүх шинжилгээний байгууллагад хийсэн 57980 шинжилгээний 38103 буюу 66%-ийг шүүх эмнэлэг дангаараа хийж байгаа нь тус салбарын эмч, шинжээчдийн хэрэгцээ, шаардлага нийгэмд их байгааг харуулж байна.

2.3 Шинжээч, албан хаагчдын эрх зүйн байдлын зохицуулалт

Боловсон хүчин бэлтгэх

Гэмт хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаанд шүүх шинжилгээний дүгнэлт, магадлагааг нотлох баримт болгон хэрэглэх, үүнд шинжээчдийн оролцоо нэмэгдэх болсноор шинжээч бэлтгэх, тэдний мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх болон мэргэшсэн боловсон хүчнээ тогтвор суурьшилтай ажиллуулах талаар багагүй хүчин чармайлт гаргаж ажилласаар иржээ. Шүүх шинжилгээний салбарын хөгжлийн эхэн үед мэргэжлийн боловсон хүчнээ ЗХУ-д бэлтгэдэг байсан бөгөөд 1964 онд анхны дээд мэргэжил эзэмшсэн криминалистикийн шинжээчдийг хүлээж авсан байдаг. Үүнээс хойш оросын их дээд сургуулиуд болон дотоод нөөц бололцоонд тулгуурлан мэргэжилтэн бэлтгэдэг болсон. Тухайлбал 1987 онд цагдаагийн байгууллагын ажилтнуудын дундаас тоо бүртгэгч-шинжээчийн 45 хоногийг дамжаагаар сургаж хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчин бэлтгэж байсанбол 1994 онд цагдаагийн дээд сургуульд Криминалистикийн шинжээчийн анги, 2003 онд Цагдаагийн академид “Криминалистикийн шинжээч” бэлтгэх ангийг⁴⁵ тус тус нээж дотооддоо дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэх болсон юм.

2.4 Хөгжлийн чиг хандлага

Монгол Улсад шүүх шинжилгээ төлөвшихөд хамгийн их хувь нэмэр, нөлөөг ЗХУ оруулсан бөгөөд үүнээс гадна бусад социалист орнуудын /БНУАУ, БНСЧСУ, БНАГУ/ туршлагыг судалж, нэвтрүүлэх ажлыг 1970-аад оноос эхлэн эрчимтэй зохион байгуулж байжээ. Энэ нь манай орны шүүх шинжилгээний хүрээнд явуулж буй үйл ажиллагаа криминалистикийн шинжилгээ, цагдаагийн шинжлэх ухааны /*police science*/ чиглэлээр хөгжих үндэслэл нь болсон байна.

1990-ээд оноос хойш манай шүүх шинжилгээний байгууллагын гадаад хамтын ажиллагаа өргөжин тэлсэн юм. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтэй уялдан зөвхөн постсоциалист орнуудаар хязгаарлагдалгүй дэлхийн бусад хөгжингүй орнуудын шүүх шинжилгээний гэхдээ гол төлөв цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох болсон байна. Тухайлбал АНУ, Япон, ХБНГУ, Францийн цагдаагийн байгууллагатай холбоотой ажилладаг болжээ.

Шүүх шинжилгээний хөгжлийн чиг хандлагад 1997 оноос эхлэн КШТ-д зэвсгийн инженер, антропологич болон хими, физик, биологоор дагнасан мэргэжилтэй хүмүүсийг шинжээчээр ажиллуулж эхэлснээр өөрчлөлт орж эхэлсэн гэж үзэж болох юм. Учир нь ийнхүү тусгай мэдлэгээр мэргэшсэн шинжээчдийн мэргэшсэн чиглэлээр дагнан ажиллуулж эхэлсэн

⁴³1963 оны 2 сарын 22-ны өдрийн Б-50 тоот тушаал

⁴⁴“Шүүх шинжилгээний статистик 2013” УБ. Эмхэтгэсэн Т.Очирбат

⁴⁵БСШУ Сайдын 2003 оны 181 тоот тушаал, ЦЕГ-ын даргын тушаал

нь гадаад орнуудын шүүх шинжилгээний хөгжлийн хэлбэрийн чиг хандлагатай буюу шүүх шинжилгээ зүйн /forensic science/үзэл баримтлал, хэлбэр илэрч эхэлснийг харуулж байна⁴⁶.

2.5 Холбогдох хууль тогтоомж

Шүүх шинжилгээний үйл ажиллагааны явц болон шинжээчийн дүгнэлт, түүний ашиглалттай холбоотой 120 орчим хууль тогтоомж, дүрэм, журам хүчин төгөлдөр үйлчилж байна. /Хавсралт 1⁴⁷/ Тухайлбал Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулиудын холбогдох заалтуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахаас гадна эдгээр хууль тогтоомжид тавигдаж буй шаардлагыг хангаж ажилладаг байна⁴⁸. Үүнээс гадна ХЗДХСайд, ЭМСайдын хамтарсан тушаалаар баталсан Гэмтлийн зэрэг тогтоох журам, Цогцост шинжилгээ хийх журам, Шүүх сэтгэц, эмгэг судлалын магадлан шинжилгээний заавар, Ялаас чөлөөлөх өвчны жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад тусалцаа үзүүлэх журам, Гарын хээний нэгдсэн сангийн журам нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг эрх зүйн баримт бичиг юм. Мөн Тусгай шинжилгээний үйл ажиллагаанд “Шүүх шинжилгээ хийх ажиллагаанд тавих шаардлага” байгууллагын стандарт /CS 11-0131:2013/, “Шүүх-биологийн шинжилгээ хийх стандарт ажлын заавар” /BIO/-6, Шүүх-ДНХ шинжилгээ хийх стандарт ажлын заавар /DNA/-26, Шүүх-химийн шинжилгээ хийх стандарт ажлын заавар /CHEM/-29, Шүүх-физикийн шинжилгээ хийх стандарт ажлын заавар /PH/-9, Шүүх-бактериологийн шинжилгээ хийх стандарт ажлын заавар /BAK/-6 гээд нийт 76 стандарт ажлын зааврыг баримталж шинжилгээний ажлыг гүйцэтгэдэг байна.

Сүүлийн жилүүдэд манай улсын шүүх шинжилгээний байгууллага төдийгүй бусад салбарт буюу хүнс, хөдөө аж ахуйн зэрэг бараа бүтээгдэхүүнд шинжилгээ хийдэг төрийн болон хувийн өмчит лабораториуд мөн адил дэлхий нийтийн жишигт үйл ажиллагааныхаа чанарыг нийцүүлж ажиллах сонирхолтой болсон. Үүний тулд олон улсын болон европын стандартуудыг судалж нутагшуулах боломжийг судлах хандлагад шилжээд байна.

2.6 Дүгнэлт

Монгол Улс дахь орчин цагийн шүүх шинжилгээний байгууллагын хөгжлийг 1958 оноос эхэлсэн, 1998 оноос шинжилгээний ажиллагаа лабораторийн системд шилжсэн гэж үздэг. Шүүх шинжилгээний байгууллагын техник технологи, боловсон хүчний чадавхийг сайжруулахад тухайн үеийн ЗХУ-ын оролцоо их байсан. Нийгэм, эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт орсон 1990 оноос хойш зөвхөн социалист орнууд гэлтгүй дэлхийн олон хөгжингүй оронтой харилцаа холбоо, хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажилах болсноор тус салбарын хөгжилд илэрхий ахиц гарсан байна. Гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчний асуудлыг судалж үзсэний үндсэн дээр 1990 оны үед шүүх шинжилгээний байгууллагын бүтэц зохион байгуулалтыг үе шаттайгаар шинэчлэн өөрчлөх талаар судалж, төсөл боловсруулж байжээ. Уг төсөлд КШТ-ийн үйл ажиллагааг криминалистикийн уламжлалт төрөл, криминалистикийн тусгай мэргэжлийн төрөл, криминалистикийн бүртгэл мэдээллийн төрөл гэсэн гурван үндсэн чиглэлээр хөгжүүлж, боловсон хүчин, техникийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар бас

⁴⁶“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 78-р тал.

⁴⁷<http://nifs.gov.mn/?/page/4.jsp> сүүлд үзсэн огноо: 2015.06.03

⁴⁸“Шүүхийн шинжилгээтэй холбоотой хууль тогтоомжийн эмхэтгэл” УБ. 2013 он.

тусгасан байдаг. Тухайн үед КШТ-ийг эрдэм шинжилгээний хүрээлэн болгож төв лабораториудыг ажиллуулах, харин аймаг, нийслэл, дүүргүүдэд анхан шатны шинжилгээ хийх хүчин чадал бүхий лабораториудтай байх, тэнд хийх боломжгүй шинжилгээг төв лабораторид хийж байх зорилго тавьж байсан нь одоо бараг хэрэгжсэн гэж үзэж болохуйц байна⁴⁹.

Манай улсын хувьд шүүх шинжилгээний байгууллага нь шинжилгээний төрөл, арга зүйн хувьд илүү криминологи талдаа, магадлах шинжилгээний төрлүүд нь криминалистикийн шинжилгээний тал дээр илүү хөгжсөн байгаагаас харахад тус байгууллага хөгжлийн түүхэндээ үргэлж цагдаагийн байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж, тэдэнтэй нягт холбоотой ажиллаж ирснийг харуулж байна. Харин сүүлийн жилүүдэд хийгдсэн бүтэц зохион байгуулалт, техник технологийн шинэчлэлийн үр дүнд шинжилгээний төрлөөр дагнасан лаборатори байгуулагдаж, тэнд тухайн чиглэлээр мэргэших боломжийг шинжээчид олгож байгаа явдал нь цаашид олон улсын хөгжлийн чиг хандлага болох шүүх шинжилгээ зүй буюу forensic science талруу хөгжих боломж бүрдэж эхэлж байна.

ШШҮХ нь 2005 оноос эхлэн ХЗЯ-ны харьяа бие даасан байгууллага болон үйл ажиллагаа явуулж буй шүүх шинжилгээ, судалгааны байгууллага болж мэргэжлийн /хими, физик, биологи гэх мэт/ шинжилгээний баг, мэргэжилтнээс бүрдсэн боловсон хүчинтэй байх хүний нөөцийн бодлого баримталж байгаа хэдий ч мэргэжлийн өндөр мэдлэгтэй, ажлын туршлага арвинтай шинжээч албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь шинжээчдийн ажлын ачаалал их, зарим шинжээчдийн ажлын байрны нөхцөл хүнд, цалин бага, нийгмийн хангамж дутмаг байгаатай холбон тайлбарладаг. Эдгээр шалтгааны улмаас мэргэшсэн, мэргэшүүлсэн боловсон хүчнээ алдаж байгаа нь үнэн боловч бодит байдал дээр мэргэжлийн шинжээчээр сонгон шалгаруулж авах үйл ажиллагааны доголдол үүнд багагүй нөлөөлдөг гэж үзэж байна. Тухайлбал мэргэжлийн шинжээчээр ажилд авч буй иргэд ихэнх төлөв дөнгөж сургуулиа төгссөн, бакалаврын зэрэгтэй мэргэжлийн диплом аваад удаагүй буюу ажлын туршлагагүйгээр шинжээчээр томилогддог. Шинжээчээр ажиллаж эхлээд ажлын ачааллаа даахгүй байх, асуудлаа сайн ойлгохгүй байх, практик мэдэхгүйгээс болж гаргасан дүгнэлт алдаатай байх магадлал их байдаг учир шантрах, эсвэл хэдэн жил ажилсны дараа мэргэжил дээшлүүлэхээр гадаад дотоодын их дээд сургуульд суралцах болсноор шинжээчээр ажиллах боломжгүй болох шалтгааныг дурдаж болох юм. Иймд мэргэжлийн шинжээчдэд тавих шаардлагыг нэмэгдүүлэх замаар шинжилгээний үр дүн болох шинжээчийн дүгнэлт, магадлагааны чанарт нөлөөлөх нь тулгамдсан асуудал болж байна.

⁴⁹“Шинжлэн магадлахгүй” УБ. 2014 он. 74-р тал.

3 ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

3.1 Унгар Улс

3.1.1 Шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, санхүүжилт

Унгар Улсын Гэмт хэргийн мэргэжлийн шинжилгээ, эрдэм шинжилгээний хүрээлэн /*Bűnügyi Szakértői és Kutatóintézet, Hungarian Institute for Forensic Science*⁵⁰/цаашид ГХМШЭШХ гэх/ нь эмч, инженер, биологич, химич, физикч, гэмт хэргийн техникийн асуудал хариуцсан байнгын мэргэжлийн алба хаагч, техникч, туслах болон бусад мэргэжлийн салбаруудын мэргэжилтэн нийлсэн 338 албан хаагчтай, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллага юм.

Эрх зүйн шинжээчийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь шүүх, нотариат, прокурор, цагдаа болон хуульд заасан бусад эрх бүхий албан байгууллага, албан тушаалтны томилгоо, захиалгын дагуушинжлэх ухаан, технологийн хөгжил, түүний шинэ үр дүнд суурилсан шинжээчийн магадлагаа, дүгнэлт гаргаж хэрэг маргааны бодит нөхцөл байдлыг тодруулах, мэргэжлийн түвшинд шийдвэрлэхэд ялангуяа мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хууль сахиулах бусад байгууллага, эрх бүхий албан тушаалтны мэргэжлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахад оршдог.

Шүүх шинжилгээний байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол тавигдах шаардлагад эрдэм шинжилгээ, судалгаа хийх ажил бас ордог. Учир нь мэргэжлийн шинжээчид шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн шинэ мэдлэг, шинэ тутам хэрэглэж, ашиглаж буй арга зүй, технологийн талаар, түүнээс гарч буй үр дүнгийн баталгаат байдлын талаар мэдлэгтэй байх шаардлага зүй ёсоор тавигддаг. Үйл ажиллагааны арга зүй, үр дүнг шалгах чухал арга бол гадаад, додоодод зохион байгуулагддаг мэргэжлийн /байгалийн шинжлэх ухааны болон криминалистикийн/ форум, хурал цуглаанд оролцож өөрсдийн ололт амжилт, туршлагыг танилцуулахаас гадна бусдын туршлагаас хуваалцаж, шинэ содон мэдээллийг харилцан солилцож үүгээр дамжуулан үйл ажиллагаандаа хяналт тавьж ажиллах явдал юм. ГХМШЭШХ нь олон улсын хэмжээний хурал, форумд тогтмол оролцож шүүх шинжилгээний хэлбэр, төрөл, арга зүйн хувьд салбартаа тэргүүдэг төдийгүй олон улсын “Чанарын баталгааны тест шалгалт”-нд орж байнга хамгийн сайн үнэлгээг авдаг байгууллагын нэг юм.

ГХМШЭШХ анх 1909 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Гэмт хэргийн нэгдсэн бүртгэлийн Албаны нэг нэгж болох Гэмт хэргийн лабораторинэртэй байгуулагдаж гарын хурууны хээ, ул мөр, бичгийн хэв, галт зэвсэг, цусны толбо, даавуун эдлэлийн шинжилгээ, фото зургийн шинжилгээний үйл ажиллагаа явуулж дүгнэлт гаргахаас гадна криминалистикийн шинжилгээний эд мөрийн баримтыг хадгалах сан бүрдүүлэх, шинжилгээний арга зүйг сайжруулах туршилтын ажил хийх үүрэг давхархариуцдаг байсан байна. Тухайлбал 1915 онд дактилоскопын шинжилгээний цуглуулга 6100 гаруй дардас хуудаснаас бүрдэж байсан байна. Харамсалтай нь дэлхийн II дайны үед шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, бүртгэлтэй холбоотой бүхий л техник, технологи, архивын сан хөмрөг устаж үгүй болсон байдаг. 1950 онд Гэмт хэргийн лабораторийг Будапештын Цагдаагийн ерөнхий газрын харьяанд шилжүүлж Гэмт хэргийн техник, бүртгэлийн дэд хэсэг⁵¹ нэртэйгээр шинэчлэн байгуулж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт оруулсан бөгөөд улсын хэмжээний


⁵⁰ <http://www.bszi.hu/> /сүүлд харсан огноо: /2015.05.30/

⁵¹ Bűnügyi Technikai és Nyilvántartási Alosztály

дактилоскопын шинжилгээний хэсэг дахин энд ажиллаж эхэлсэн байна. Үүнээс хойш тус байгууллагын үйл ажиллагааны төрөл, цар хүрээг нэмсэн бүтцийн өөрчлөлт цөөнгүй хийгдсэний нэг нь 1961 онд Гэмт хэргийн техникийн хүрээлэн болгосон өөрчлөлт байсан юм. Ингэснээр үйл ажиллагааны хүрээгээ тэлж шинэ төрлийн, биохими, хийн хроматографийн нарийвчилсан шинжилгээ болон бусад шинжилгээ хийх хүний нөөцийн болон техник технологийн боломж бүрджээ. 1990 оноос эхлэн ГХМШЭШХүрээлэн болж одоогийн бүтцээрээ үйл ажиллагаа явуулж байна.

ГХМШЭШХ нь 1990-1994 онд Дотоод хэргийн яамны, 1994-2003 онд Цагдаагийн ерөнхий газрын, 2003-2006 онд Дотоод хэргийн яамны, 2006-2010 онд Хууль зүйн яамны, 2011 оноос Цагдаагийн ерөнхий газрын харьяа Гэмт хэргийн техник, мэргэжлийн шинжилгээний төв хэлтэст тус тус харьяалагдан үйл ажиллагаа явуулж байна.

ГЭМТ ХЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БОЛОН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН БҮТЭЦ /2015 ОН/



Шинжлэх ухааны үүрэг гүйцэтгэх зорилгыг хариуцан гэмт хэргийн төлөө шалбарлаж хэлтэс болон лабораториудыг хөгжиж байна. Тухайлбал анагаахын шинжилгээний хэлтсээс ДНХ-гийн шинжилгээнд үндэслэн хувь хүнийг тодорхойлох Хүний генетикийн шинжилгээний хэлтэс, Хими-Физикийн шинжилгээний хэлтсээс мансууруулах бодис, түүнтэй адил нөлөө үзүүлдэг бодис болон шатамхай материалын шинжилгээний хэлтэс бие даан гарч үйл ажиллагаагаа эхлээд байна.

Улсын хэмжээний төв лабораторийн хувьд дараах шинжилгээнүүдийг зөвхөн тус хүрээлэн гүйцэтгэж шинжээчийн дүгнэлт гаргах онцгой эрхтэй байдаг. Үүнд:

- мансууруулах бодисын шинжилгээ, хурууны болон алганы хээний шинжилгээ, адилтгал,

- биологийн түүн дотроо ДНХ-тай холбоотой бүх төрлийн шинжилгээ, мөн цусан дахь алкохолын хэмжээг тогтоох, цусан толбо, үрийн шингэн, үс, хялгас, атом, нүүрс хүчлийн хийн, эсийн шинжилгээ болон араг ясаар хэн болохыг тогтоох шинжилгээ,
- галт зэвсэг ашиглан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эзэн нь үл мэдэгдэх галт зэвсэг, хонгио, сумны шинжилгээ,
- Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны явцад бичгийн хэв, баримт бичгийн /гар бичмэл, гарын үсэг, хуурамчаар үйлдсэн, санаатайгаар балласан баримт бичиг, засвар оруулсан баримт бичиг гэх мэт/шинжилгээ
- эрүүгийн хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад
 - ул мөрийн /гутал, дугуй, түлхүүр, цоож, хүн амьтны хазсан мөр гэх мэт/ шинжилгээ,
 - баримт бичгийн /эх хувь эсэхийг тогтоох, хуурамчаар үйлдсэн баримт бичгийн төрөл, ташигласан техникийн түвшинг тогтоох, тамга, дардасны адилтгал гэх мэт/ шинжилгээ,
 - химийн /шатамхай шингэн, эрдэс бодис, шатахуун, тос, тосолгооны материал гэх мэт/ шинжилгээ,
 - физикийн /хуурамч мөнгөн тэмдэгтийн шинжилгээ, түүнийг бэлтгэсэн техник хэрэгслийн түвшинг тогтоох гэх мэт/ шинжилгээ,
 - геологийн болон ботаникийн шинжилгээ,
 - биологийн /нас барсан хугацааг шавьжны туслалцаатайгаар тогтоох/ болон бусад мэргэжлийн шинжилгээний үйл ажиллагаа багтдаг байна.

Хүрээлэн нь цагдаагийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий улсын төсвөөс санхүүждэг, бие даасан, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх эрх, үүрэгтэй цагдаагийн шинжилгээний байгууллага. Мөн хууль тогтоомжид заасан онцгой эрхийн дагуу зарим шинжилгээг зөвхөн тус хүрээлэн хийх, шинжээч томилох, гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагааны зарим техник талын үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй төрийн байгууллага юм. Тус хүрээлэн Дотоод хэргийн яамны харьяа байгууллага бөгөөд бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулах, удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх зэрэг асуудлыг ДХСайдын тушаалаар шийдвэрлэдэг бол “дунд удирдлага”-ын буюу үйл ажиллагааны чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаатай холбоотой удирдах ажлыг Цагдаагийн ерөнхий газар хэрэгжүүлдэг байна.

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь хууль зүйн мэргэжлийн шинжилгээтэй холбоотой үйл ажиллагаа явуулах бөгөөд үүнээс гадна бусад хууль сахиулах, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, хууль зүйн шинжилгээ хийх, бусад хэвлэн нийтлэх, нийтийн аюулгүй байдал, дэг журамтай холбоотой судалгаа шинжилгээ хийх, түүнийг туршилтын аргаар хөгжүүлэх эрх, үүрэгтэй.

Хууль зүйн мэргэжлийн шинжилгээний үйл ажиллагааг уламжлалт криминалистикийн шинжилгээ /ул мөр, дактилоскоп, галт зэвсэг, баримт бичиг, гар бичмэлийн шинжилгээний төрлөөр/ болон форенсик буюу мэргэжлийн шинжилгээний /микро эд, эсийн шинжилгээ, форенсик геологийн шинжилгээ, мансууруулах бодисын шинжилгээ, химийн бодисын шинжилгээ, хууль зүйн биологийн болон анагаахын шинжилгээ, даавуун эдлэлийн шинжилгээ, ДНХ-ийн шинжилгээ/ гэсэн ерөнхий төрлөөр ангилдаг байна.

3.1.2 Шинжээч, албан хаагчдын эрх зүйн байдлын зохицуулалт

Мэргэжлийн шинжээч бэлтгэх тогтолцоо

Хууль зүйн мэргэжлийн шинжээч бэлтгэх асуудлыг зохицуулдаг гол хууль нь “Хууль зүйн мэргэжлийн шинжээчийн мэргэших салбар, төрөл болон түүнтэй холбогдох мэргэшүүлэх

сургалт болон бусад мэргэжлийн шаардлагын тухай⁵² 2006 оны Хууль зүйн сайдын тушаал юм.

Хууль зүйн мэргэжлийн шинжээч бэлтгэх, мэргэшүүлэх, шинжээчид тавигдах мэргэжлийн шаардлагыг Хууль зүйн сайд шинжээчийн үйл ажиллагаатай холбогдох асуудал эрхэлсэн сайдтай хамтран зөвшилцсөний үндсэн дээр тогтоодог⁵³. Өмнөх шаардлагыг хангасан шинжээчийн хувьд хууль зүйн шинжээчийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх эрх үүсдэг. Зарим мэргэжлийн хувьд хууль зүйн эмч шинжээчээр бүртгүүлэхэд тухайн мэргэжлийн холбоо, танхимын гишүүн байхыг шаарддаг. Хууль зүйн мэргэжлийн шинжилгээний төрөлд хамаарах мэргэжлийг хууль тогтоомжоор тогтоох бөгөөд энэхүү мэргэжлийн шинжээчдийн нэгдсэн жагсаалтад бүртгүүлэхийн тулд хүсэлт гаргагч их дээд сургуулийн сургалтад хамрагдаж боловсролын гэрчилгээ авсан мэргэжлээрээ практик дээр ажилласан туршлагын хугацааг харгалздаг байна. Мэргэжлийн онцлог, шинжилгээний ажлын хэлбэр, төрөл, шинжээчийн ур чадвар, туршлагаас хамааран ажлын туршлагыг 3-15 жил байхаар ялгаатай зохицуулсан байдаг. Ерөнхий зохицуулалтын дагуу ажлын туршлагын хувьд дараах наад захын шаардлага хангасан байх шаардлагатай. Үүнд⁵⁴:

- Их дээд сургуульд суралцаж мэргэжил эзэмшсэнээс хойш 5 жил мэргэжлээр ажилласан байх,
- Хэрэв мэргэжлийн боловсрол олгох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагад мэргэжил эзэмсэн бол гэрчилгээ авснаас хойш 10 жил мэргэжлээр ажилласан байх,
- Хууль зүйн мэргэжлийн шинжилгээний байгууллагад шинжээчийн туслахаар ажиллаж байгаа бол мэргэжил эзэмшсэнээс хойш шинжилгээний байгууллагад 3 жил тасралгүй ажилласан байх шаардлага тавигддаг байна. Мөн мэргэжлээр ажилласан туршлагаас гадна шинжээчээр бүртгүүлэхэд мэргэшлүүлэх болон үргэлжилсэн сургалтад хамрагдсан байх давхар шаардлага тавигддаг.

Унгарын шүүх шинжилгээний төв байгууллага болох ГХМШЭШХ-ийн албан хаагчид хууль зүйн албан хаагч⁵⁵, төрийн тусгай үйлчилгээний буюу цагдаагийн алба хаагч, төрийн албан хаагч, хөдөлмөрийнхуулийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажил гүйцэтгэгч алба хаагч гэсэн 4 ангилалд хуваагддаг байна.

Мэргэжлийн шинжээчийн ажлын хөлс, зардлыг тооцох тухай

Анх 1986 онд Хууль зүйн сайдын 3/1986 (II.21.) тоот тушаалаар хууль зүйн мэргэжлийн шинжээчийн ажлын хөлс, зардлыг тооцох аргачлалыг баталсанаас хойш мөрдөж байна. Уг тушаалын хавсралтаар шинжилгээний төрөл тус бүрээр шинжилгээний ажиллагааны зардлыг тогтоосон байдаг байна. Шинжилгээний ажлын зардлыг нэг дээжид хийсэн шинжилгээ тус бүрийн өртгийг тооцох эсхүл шинжилгээний ажилд зарцуулсан цагийн хөлсийг тооцох гэсэн хоёр аргаар тооцдог бөгөөд гарсан зардлыг гэм буруутай нь тогтоогдсон этгээдээр нөхөн төлүүлдэг байна. Тодруулбал нэг шинжилгээний зардлыг тооцохдоо шинжилгээ хийлгэхээр илгээсэн дээжийн тоогоор бус нэг дээж дээр хийсэн шинжилгээ тус бүрээр төлбөрийг тооцдог

⁵²az igazságügyi szakértői szakterületekről, valamint az azokhoz kapcsolódó képesítési és egyéb szakmai feltételekről/9/2006 (II.27) IM rendelet. Цахим хуудас:

http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A0600009.IM /сүүлд үзсэн огноо: 2010.06.01/

⁵³9/2006 (II.27) IM rendelet

⁵⁴9/2006 (II.27) IM rendelet 6.§

⁵⁵ 2013. évi CCXLIII. Törvény az egyes igazságügyi, jogállási és belügyi tárgyú törvények módosításáról, цахим хуудас: <http://www.opten.hu/2013-evi-ccxliii-torveny-j242358.html>

байна. Аргачлалд шинжилгээний төлбөр – 4000 форинт⁵⁶/шинжилгээ /ойролцоогоор 14,4 ам.доллар/ байхаар тогтоосон бол мэргэжлийн дүгнэлт бичих ажлыг 300 форинт/1 хуудас /ойролцоогоор 1,7 ам.доллар/ гэж үнэлдэг байна. Харин өмнөх аргаар зардлыг тооцож болохгүй үйл ажиллагааны зардлыг цагийн хөлсөөр тооцдог байна. Тухайлбал шинжилгээнд илгээсэн дээжийг задлах, савлах, бүртгэх ажлын зардлыг цагийн хөлсөөр тооцож энэ төрлийн ажил гүйцэтгэсэн шинжээчийг ажлыг 4000 форинт⁵⁷/цаг гэж үнэлдэг байна.

3.1.3 Унгарын Хууль зүйн мэргэжлийн шинжээчдийн танхим

1996 онд⁵⁸ Унгарын Хууль зүйн мэргэжлийн шинжээчдийн танхим /*A Magyar Igazságügyi Szakértői Kamara*/ цаашид УХЗМШТ гэх/ болон 8 бүс нутгийн хэмжээний Хууль зүйн мэргэжлийн шинжээчдийн танхим байгуулагдсан бөгөөд одоо нийт 5000 гаруй гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. УХЗМШТ нь хуулиар хүлээсэн тодорхой чиг үүргийн дагуу төрийн үйлчилгээ үзүүлдэг, бие даасан захиргаатай, гишүүнчлэлтэй, өөрөө өөрийгөө удирддаг хуулийн этгээд юм. Танхимын гишүүд мэргэжлийн үйл ажиллагаагаа инженерийн, хүний биологийн, газар тариалангийн, криминалистикийн, бусад шинжлэх ухааны салбар чиглэлийн дагуу мэргэжлийн зөвлөл байгуулж ажилладаг. Хууль зүйн шинжээчийн үйл ажиллагаа явуулахын тулд энэ танхимын гишүүнчлэлтэй байх шаардлага тавигддаг. Хууль зүйн шинжээчийн үйл ажиллагааны тухай хуулийг⁵⁹ дагалдан гарсан олон эрх зүйн акт байдаг ба шинжээч болох, шинжээчийн сургалт, шинжээчийн үнэмлэх олгох, шинжээчийн дүгнэлт гаргах асуудлыг сайдын тушаалаар зохицуулдаг.

Танхим нь гишүүдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг төлөөлөх эрхтэй. Үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хууль зүйн шинжээчдийн үйл ажиллагааны үндсэн дүрэм боловсруулах, шинжээч томилох болон шинжээчийн үйл ажиллагааны ерөнхий болон дагаж мөрдвөл зохих мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмыг тодорхойлох зэрэг эрх эдэлдэг. Мөн хууль зүйн мэргэжлийн шинжээчдийн мэргэжлийн болон ёс зүйн асуудалд хяналт тавих, тэдний эрх ашинжээчийн ажлын хөлс тогтоох, мэргэжлийн боловсрол олгож буй их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт санал оруулах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах эрх эдлэх бөгөөд эдгээр нь үйл ажиллагааны үндсэн зорилго болдог байна.

3.1.4 Холбогдох хууль тогтоомж

Унгар Улсад хууль зүйн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн шинжээчдийн эрх зүйн байдлыг зохицуулдаг гол хууль нь “Хууль зүйн шинжээчийн үйл ажиллагааны тухай” 2005 оын 47 дугаар хууль⁶⁰ юм. Тус хууль нь ерөнхий хэсэг, шинжээч болох дүрэм, нэрсийн жагсаалт, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлийг нэмэх хүсэлт гаргах тухай, нэрсийн жагсаалтаас хасах, гомдол барагдуулах, шинжээчийн эрх, үүрэг, шинжээч томилох, шинжээчийн дүгнэлт, шинжээчийн хөлс, шинжээч бэлтгэх, шинжээчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, шүүх шинжилгээний байгууллагууд, шүүх шинжилгээний зөвлөл, шинжээчид нэр дэвшигч,

⁵⁶Унгар улсын мөнгөтэмдэгт форинт. Форинтын ханш :277,1 форинт 1 ам.доллартай тэнцэж байна. Цахим хуудас: <http://www.mnb.hu/arfolyamok> . Сүүлд үзсэн огноо: 2015.06.10

⁵⁷Унгар улсын мөнгөтэмдэгт форинт. Форинтын ханш :277,1 форинт 1 ам.доллартай тэнцэж байна. Цахим хуудас: <http://www.mnb.hu/arfolyamok> . Сүүлд үзсэн огноо: 2015.06.10

⁵⁸Хууль зүйн мэргэжлийн шинжээчдийн танхим байгуулах тухай 1995 оны 114 дүгээр хууль

⁵⁹2005. évi XLVII. tv. az igazságügyi szakértői tevékenységről

⁶⁰http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A0500047.TV /сүүлд харсан огноо: 2015.05.21/

мэргэжлийн зөвлөх, болон туслахтай холбоотой зохицуулалт болон шинжээчийн арга зүйн хуудас гэсэн 16 хэсэг 34 зүйлтэй юм.

Хууль зүйн мэргэжлийн шинжээчийн болон, УХЗМШТ, ГХМШЭШХүрээлэнгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг олон төрлийн хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал болох холбогдох үйл ажиллагааны стандарт болон журмаар зохицуулдаг байна. Жишээлбэл:

1. Хууль зүйн мэргэжлийн шинжээчийн үйл ажиллагааны тухай хууль⁶¹
2. Захиргааны байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний ерөнхий дүрэм⁶²
3. Зөрчлийн тухай хууль⁶³
4. Ял, шийтгэлийн процессын тухай хууль⁶⁴
5. Хууль зүйн мэргэжлийн шинжээчдийн танхимын тухай хууль⁶⁵
6. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁶⁶
7. Хууль зүйн салбарын албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль
8. Цагдаагийн байгууллага, Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээний тухай Засгийн газрын тогтоол
9. Мэргэжлийн шинжээч томилох шийдвэрийн агуулга, хэлбэрт тавигдах шаардлага⁶⁷
10. Мэргэжлийн шинжээчийн шинжилгээний ажлын хөлс, зардал⁶⁸
11. Даавуун эдлэл, үс, атомын /diatomaceous/ дээж авах заавар⁶⁹ зэрэг гол хууль тогтоомжийг дурдаж болох юм.

3.1.5 Дүгнэлт

Унгар Улсад төрийн байгууллага, хувийн өмчит хуулийн этгээд болон хувь хүн шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулах эрх авах боломж нээлттэй. Эдгээрийн үйл ажиллагааг олон хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд “Хууль зүйн шинжээчийн үйл ажиллагааны тухай” 2005 оын 47 дугаар хуулиар⁷⁰ гол гол асуудлыг зохицуулсан байдаг. Унгарт шүүх шинжилгээ гэхээс илүү хууль зүйн шинжилгээ гэх нэр томъёог хэрэглэдэг. Учир нь зөвхөн хууль сахиулах, хууль хэрэгжүүлэгч байгууллагын захиалгаар тодорхой гэм буруутай үйлдлийн улмаас үүссэн эд мөрийн баримтыг тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд нөлөөлөхүйц бодит нөхцөл байдлыг илрүүлэхэд нотлох баримтад хууль зүйн талаас нь ач холбогдол бүхий шинжилгээ хийж, дүгнэлт гаргах замаар дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн шинжилгээ хийдэг. Хууль зүйн шинжилгээний үйл ажиллагаа явуулах эрхийг хууль тогтоомжид заасан мэргэжил эзэмшсэн, түүний дотор тодорхой чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн туршлагатай шинжээч мэргэжилтэнд олгодог бөгөөд энэ эрхийг УХЗМШТанхимын гишүүнд олгодог байна.

⁶¹2005. évi XLVII. törvény az igazságügyi szakértői tevékenységről

⁶²2004. évi CXL. törvény a közigazgatási hatósági eljárás és szolgáltatás általános szabályairól

⁶³1999. évi LXIX. törvény a szabálysértésekről

⁶⁴1998. évi XIX. törvény a büntetőeljárásról

⁶⁵1995. évi CXIV. törvény az igazságügyi szakértői kamaráról

⁶⁶1952. évi III. törvény a polgári perrendtartásról

⁶⁷Kirendelő határozat tartalmi és formai követelményei. 1998. évi XIX. törvény, 282/2007. (X.26.) Korm. rendelet, 26/2009. (OT 15.) ORFK utasítás, цахим хуудас:<http://bszki.hu/page.php?582>

⁶⁸A szakértői vizsgálatok díja és költségei цахим хуудас:

http://www.bszki.hu/e107_files/downloads/kabitoszer_dijjegyzek.pdf

⁶⁹Mintavételi útmutató szövettani, szörképlet és diatóma vizsgálatokhoz, цахим хуудас:

http://www.bszki.hu/e107_files/downloads/mintaveteli_utmutato_orvosszakertoi.pdf

⁷⁰http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A0500047.TV /сүүлд харсан огноо: 2015.05.21/

Хууль зүйн шинжээч нь өөрийн мэдлэг, ур чадварт тулгуурлан орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололтод суурилсан үйл ажиллагаагаар иргэний болон гэмт үйлдэлтэй холбоотой үүссэн маргаантай асуултад хариулт өгөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хувиараа ажиллаж буй шинжээч нь ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр гэрээнд заасан асуудлын хүрээнд магадлах шинжилгээ хийдэг. Эдгээр шинжээчдийг бие даасан шинжээчид гэж нэрлэдэг. Ганцаараа ажилладаг бие даасан шинжээчийн гаргасан дүгнэлт, магадлагааг ихэнхи тохиолдолд хэргийн оролцогчдын аль нэг тал нь үгүйсгэн дахин шинжээч томилох хүсэлт гаргадаг сул талтай байдаг бол багаар буюу ямар нэгэн бүтэц зохион байгуулалтад орсон шинжээчдийн бүлгээс гаргасан дүгнэлт, магадлагааг ийнхүү үгүйсгэх магадлал харьцангуй бага байдаг. Зарим шинжилгээг зөвхөн ГХМШЭШХ-д гүйцэтгэх онцгой эрх олгодог нь үүнтэй холбоотой. Энэ нь нэгдүгээрт тус хүрээлэн нь техник, технологийн хувьд европын стандартад нийцсэн, магадлан итгэмжлэгдсэн лаборатори, шинжилгээний арга зүйтэй, хоёрдугаарт шинжилгээний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх боломжгүй, гуравдугаарт тэдний гаргасан дүгнэлт, магадлагаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдаг тул маргах, үгүйсгэх асуудал ховор гардаг зэрэг давуу тал олонтой байдагт оршино. Тухайлбал улсын хэмжээнд гарын хээний нэгдсэн бүртгэлийн сан үүсгэх, адилтгалын шинжилгээ хийх эрх зөвхөн энэ байгууллагад олгогдсон байдаг.

Унгар Улсад хууль зүйн шинжээчдийн нэгдсэн бүртгэлийг Хууль зүйн шинжээчдийн танхим хөтөлдөг бөгөөд тус танхим нь төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн бус байгууллага юм.

Тус улсын шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа үндсэндээ хоёр чиглэлээр буюу уламжлалт криминалистикийн шинжилгээ болон форенсик шинжилгээ гэсэн хоёр чиглэлээр хөгжиж байгааг судалгааны ажлаас харж болно. Шинжлэх ухаан, техник технологийн дэвшилтэт энэ үед шүүх шинжилгээний үйл ажиллагаа форенсик буюу мэргэжлийн/тусгай шинжилгээний чиглэлээр илүү далайцтай хөгжиж буй дэлхий нийтийн хандлагад нийцсэн хөгжлийг уламжлалт криминалистикийн шинжилгээний аргатай хослуулан хэрэглэж буйг тус улсын жишээнээс харж болохоор байна.

Хууль зүйн шинжилгээг төрийн байгууллагаас гадна хувийн өмчит хуулийн этгээд болон хувь шинжээч гэрээний үндсэн дээр магадлах шинжилгээг хийж гүйцэтгэдэг учир шинжилгээний үйл ажиллагааны үе шат, үнэ тарифыг нэгдсэн байдлаар зохицуулсан журам үйлчилдэг нь шүүх шинжилгээний үйлчилгээ үзүүлж буй болон үйлчилгээ авч буй хэнд ч зардлын талаарх ойлголтыг нэг мөр ойлгомжтой болгож байгаа нь онцлог байлаа. Мөн хууль зүйн шинжээчээр ажиллах сонирхол бүхий этгээдийг нэгдсэн бүртгэлд бүртгэхэд тавигдаж буй шаардлага мэргэжил, мэдлэг, ажлын өндөр туршлага шаардаж байгаа нь тэдний гаргасан дүгнэлт, магадлагааны чанарт шууд нөлөөлж байна. Шинжээчдийн үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх үүднээс мэргэшүүлэх болон давтан сургалтад тогтмол хугацааны давтамжтай оролцох үүрэг хүлээлгэдэг, мөн олон улсынхэмжээнд болон дотоодын хэмжээнд зохион байгуулагдаж буй мэргэжлийн шинжилгээний хурал, форумд оролцож өөрсдийн хүрсэн үр дүнг танилцуулахын зэрэгцээ бусдаас суралцах боломжоор хангаж байгаа нь шинжээчдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх чухал арга хэмжээ болдог байна.

3.2 БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

3.2.1 Шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт

Солонгосын шүүх шинжилгээ нь шүүх эрх мэдлийн тогтолцоонд харьяалагддаг бүтэц юм. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэг хүлээсэн эрх бүхий албан тушаалтнууд нь бүгд

прокурорын хяналтанд үйл ажиллагаа явуулдаг. Прокурорын байгууллага дангаараа мөрдөн шалгах ажиллагааг бүхэлд нь гүйцэтгэх боломжгүй учир шүүх шинжилгээний ажлыг шүүхийнцагдаагийн алба хаагчдад хариуцуулдаг. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчид мөрдөн шалгах ажиллагаанд оролцож шинжилгээний ажлыг хариуцан гүйцэтгэдэг бөгөөд цөөн хэдэн тохиолдолд л прокурор хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд шууд оролцох эрхтэй байдаг байна. Харин хэрэг хянан шалгаж, яллах ажиллагааг зөвхөн прокурор явуулах бөгөөд шүүх энэхүү ажиллагаанд оролцдоггүй.

Солонгос улсын шүүх системд цэргийн болон далайн гэсэн тусгайлсан шүүхийн цагдаа байдаг бөгөөд цагдаагийн байгууллага, прокурорын газар, цэрэг болон далайн цагдаагийн газар нь өөр өөрийн гэсэн тусгайлсан чиг үүргийн хүрээнд өөрийн шүүх шинжилгээний байгууллага, лабораториудаар магадлагаа, дүгнэлт гаргуулдаг байна. Үүнээс харахад ихэнхи шүүх шинжилгээний байгууллагууд буюу прокурор, цагдаагийн болон тусгай шүүхийн цагдаагийн газрын */Special judicial police/* шүүх шинжилгээний байгууллага өөрсдийн төмөр зам, хүрээлэн буй орчин, хоол хүнс болон засан хүмүүжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаатай хамааралтай шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлсэн байх ба эдгээр нь хоорондоо үйл ажиллагаагаараа харилцан холбогдсон байдаг. Солонгосын шүүх шинжилгээний томоохон хүрээлэн, төвүүдийн үйл ажиллагаа, чиг үүргээс товч танилцуулъя.

NFS National forensic service буюу Үндэсний шүүх шинжилгээний байгууллага⁷¹

Үндэсний шүүх шинжилгээний байгууллага /цаашид НФС/ нь Солонгос улсад шүүх шинжилгээний үйл ажиллагааг хариуцсан төв байгууллага юм. Улсын хэмжээний албан ёсны шүүх шинжилгээний байгууллагын хувьд энэхүү байгууллагын үүсэл хөгжил, үйл ажиллагаа нь Солонгос улсын шүүх шинжилгээний салбарын түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой. НФС нь анх 1948 Цагдаагийн газрын шүүх шинжилгээний анагаах ухаан, шүүх шинжилгээний хими болон хурууний хээний шинжилгээ зэрэг асуудлуудыг хариуцсан хэлтэс байгуулагдсанаар үүссэн гэж үздэг. Дараах томоохон өөрчлөлт 1955 онд явагдсан бөгөөд энэ шинэчлэлийн хүрээнд шүүх шинжилгээний байгууллага нь Цагдаагийн газрын харьяанд үйл ажиллагаа явуулдаг бие даасан байгууллага болж хоёр хуваагдсан юм. Үүнээс хойш гэмт хэргийн шинжтэй үзэгдлүүдэд шүүх шинжилгээний байгууллагад цугларсан нотлох баримтуудыг шинжлэн судлах хэлбэрээр цагдаагийн байгууллагаас явуулж буй мөрдөн байцаалтын ажилд дэмжлэг үзүүлдэг болжээ. Мөн түүнчлэн бие даан гарсан энэ байгууллага нь шүүх шинжилгээний техник, хэрэгсэлийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэсэн юм. 1970-аад оны эдийн засгийн сэргэн мандалтын үед НФС-ийн үйл ажиллагаа улам өргөжсөн. 1986 онд тусгайлан өөрсдийн барилгатай болсон байна. 1993 оноос эхлэн НФС өөрийн салбар байгууллагуудаа Сөүлийн хотоос гадагш орон нутагт байгуулж эхэлсэн юм.

НФС нь дэлхийн хэмжээнд үйл ажиллагаагаараа хүлээн зөвшөөрөгдсөн шүүх шинжилгээний байгууллага болох гэсэн үндсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд 2010 онд НФС-гийн бүтэц, удирдлага зохион байгуулалт өөрчлөгдөж *Үндэсний шинжлэх ухааны судалгааны хүрээлэн /National institute of scientific investigation/* болон өөрчлөгдсөн байна. Энэ байгууллага нь Цагдаагийн байгууллагын харьяаллаас гарч Нийтийн захиргаа, аюулгүй байдлын яамны харьяа байгууллага болсон юм.

⁷¹https://books.google.mn/books?id=GvRMBgAAQBAJ&pg=PA193&lpg=PA193&dq=forensic+science+in+Korea+research&source=bl&ots=ojY9UuYp4_&sig=Ndf0dbIJXEPxmvzQHrOHv2ZbgCk&hl=en&sa=X&ei=gnBRVYTSNJXYoASSq4HoCw&ved=0CDEQ6AEwAw#v=onepage&q=forensic%20science%20in%20Korea%20research&f=false

2013 оны 07 дугаар сарын байдлаар НФС нь шүүх шинжилгээний анагаах, хими, хорт бодис болон дижитал шүүх эмнэлгийг видео дүн шинжилгээ, шүүх шинжилгээний инженер/авто тээврийн ослын дүн шинжилгээ гэх мэт/ гэх зэрэг олон төрлийн шинжилгээний ажлын хүрээнд шүүх шинжилгээний судалгаа, хөгжил болон боловсролын үйл ажиллагааг цогцоор нь 330 гаруй албан хаагчдын бүрэлдэхүүнтэй гүйцэтгэдэг бөгөөд эдгээрийн 250 гаруй нь мэргэшсэн шинжээч байдаг байна.

НФС нь бүтэц, зохион байгуулалтын хувьд Шүүх шинжилгээний газар болон Эмнэлгийн шинжээчдийн төв гэсэн үндсэн хоёр чиглэлээр хуваагддаг бөгөөд эдгээрт шүүх шинжилгээний төрлөөр хуваагдсан 10 салбар, 34 хэлтэс багтдаг байна. НФС-ийн орон нутгийн салбар байгууллагууд Дэжүн, Бусан, Дэгү, Гуанжуд байрлаж ажилладаг байна. Хамгийн сүүлийн тоо мэдээнээс харахад одоогийн байдлаар 350 гаруй экспертүүд жил бүр ойролцоогоор 30000 гаруй хэрэг дээр ажилладаг.

*Солонгос улсын лабораторийн магадлан итгэмжлэлийн схемын байгууллага*⁷²- нь нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт ISO/IEC 17025 : 2005-ийн дагуу магадлан итгэмжлэл олгодог бөгөөд 2004 онд НФС-ийн ДНХ болон Наркотикийн салбарт, 2006 онд цусан дахь алкохолын хэмжээ тогтоох, эм, хорт бодис, физик болон авто замын салбарт магадлан итгэмжилсэн байна. Тус стандарт нь лабораторийн чанартай зохион байгуулалтын системийн үйл ажиллагаа болон хүрээг тодорхойлж техникийн чадварыг харуулдаг⁷³ буюу дээрхи лабораториудад олон улсын түвшинд шаардлагад нийцсэн шинжилгээний ажил хийж байгааг нотолж байгаа хэрэг юм.

НФС-ийн үндсэн чиг үүргийн хүрээнд түүний салбар байгууллагуудын хийж гүйцэтгэдэг шинжилгээний талаар товч танилцуулга

Салбар	Чиг үүрэг
Шүүх шинжилгээний ДНХ-ын газар	<ul style="list-style-type: none"> - Онц хүнд гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, бэлгийн гэмт хэрэг болон авто машины ослын нотлох баримтуудад дүн шинжилгээ хийх -Үл танигдах цогцсийг тодорхойлох, шүүх шинжилгээний микробын холбогдолтой ажил гүйцэтгэх - ДНХ-гийн мэдээллийн бааз ажиллуулах -Сураггүй болсон хүүхдийн гэр бүлийн харилцаа холбоог баталгаажуулах, хүний удам угсааг тодорхойлох
Мансууруулах бодис болон хорт бодис	<ul style="list-style-type: none"> - Гэмт хэрэгтэй холбоотойгоор мансууруулах эм болон хор хэрэглэсэн этгээдүүдэд шинжилгээ хийх болон судалгаа явуулах - Хоол хүнсний ариун цэвэр болон хор хөнөөлийн судалгаа, шинжилгээ хийх - Мансууруулах бодис буюу наркотикийн судалгаа, шинжилгээ хийх: -Хууль бус мансууруулах эмнээсүүдэлтэй гэмт хэрэгт шинжилгээний нотлох баримтаар хангах, шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодисыг илрүүлэх

⁷²<http://152.99.46.10:8099/english/AboutKolas/Introduction.aspx>

⁷³<http://152.99.46.10:8099/english/Directory/DirectoryList.aspx?Accredit=02>

<p>Химийн дүн шинжилгээ</p>	<ul style="list-style-type: none"> - Тогтвортой изотоп болон ул мөрийн хүчин зүйлийг ашиглан химийн үйл ажиллагаа явуулах - Үртэс, давирхай, хөрс, шил, үс, будаг гэх мэт ул мөрийн материалуудад дүн шинжилгээ хийх. - Задлан шинжилгээний дээж болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодогч нарын цусан дахь алкогольны дүн шинжилгээ хийх -Галдан шатаагч болон уусгагч эд зүйл, материалын шатамхай чанарыг судлах - Хүчтэй хүчил, хүнд метал болон химийн бодис гэх зэрэг онц аюултай материалуудыг судлах
<p>Шүүх шинжилгээний аюулгүй байдал</p>	<ul style="list-style-type: none"> - Аюулгүй ажиллагаа ба гэнэтийн ослын мөрдөн шалгалт ба судалгаа - Гамшиг, сүйрлийн шалтгааныг мөрдөн шалгах - Гал болон тэсрэх бодисын мөрдөн шалгалт ба судалгаа - Галт зэвсэг, тэмдэг, цусны хэв маягын мөрдөн шалгалт ба судалгаа
<p>Дижитал технологи болон Био үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> - Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүрс, зураг, бичлэгт чанарыг сайжруулах түүнийг тайлбарлах болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй хуурамч мэдээллийг илрүүлэх, - Гар утас, хард-диск, флаш зэрэг тоон төхөөрөмж дэх мэдээллийг засварлах, сэргээх, - 2D/3D хэмжээст Био мэдээллийг тодорхойлох, загварчлах, дүн шинжилгээ хийх болон өндрийн хэмжээ болон дүрс зэрэг био мэдээллийг тодорхойлох болон загварчлах, - Дуу хоолойг таних, аудио бичлэгийг баталгаажуулах, түүнийг сайжруулах, модуляц дуу чимээг таних, цахилгаан дуу авиа болон цахилгаан бус дуу авианд мөрдөн шалгалт, дүн шинжилгээ хийхдуу авианы Investigation, - Асуултын баримт бичигт дүн шинжилгээ хийх, тамга тэмдэг, бичгийн хэвийг тодорхойлон таних, хуурамч баримт бичиг, валютыг илрүүлэх,
<p>Авто замын хөдөлгөөний ослын дүн шинжилгээ</p>	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлийг илрүүлэх, тээврийн хэрэгслийн ослын улмаас үүссэн нөхцөл байдлыг загварчлан нөхөн сэргээх, - Зам тээврийн осол гаргаад хэргийн газраас зугтсан этгээдийн тээврийн хэрэгслийг тодорхойлох, тухайн тээврийн хэрэгслийн дугаарыг тодорхойлох,

<p>Сэтгэл судлалын шүүх шинжилгээн ий газар</p>	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл судлалын аргаар хууран мэхлэлтийг илрүүлэх, - EEG⁷⁴-г ашиглан нуугдсан мэдээллүүдийг илрүүлэх тест явуулах, - Мэдүүлэгт үндэслэн дүн шинжилгээ хийх, - Хууль зүйн дүгнэлт гаргахад туслах зорилгоор хувийн зан чанар, оюун ухаан, мэдлэг чадвар болон сэтгэл хөдлөлд сэтгэл зүйн үнэлгээ хийх,
<p>Эмнэлгийн мэргэжилтн ий газар</p>	<ul style="list-style-type: none"> - задлан шинжилгээ, цогцост нарийвчилсан үзлэг хийх, шүүх эмгэг судлалын шинжилгээ, шүүх шүд судлалын шинжилгээ - Үхлийн шалтгааныг судлах, шүүх эмнэлгийн туршлагыг бий болгох, шүүх эмнэлэгийн судалгаа явуулах

Прокурорын байгууллага ба Үндэсний дижитал шүүх шинжилгээний байгууллага /National Digital forensic center NDFC/⁷⁵

Солонгос улсын Прокурорын ерөнхий газар анх 1979 онд lie detector буюу полиграфыг нэвтрүүлснээр шинжлэх ухаанд тулгуурласан шүүх шинжилгээ буюу танадлан шинжлэх үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүхтэй. Үүнээс хойш 1991 он хүртэл бичиг баримтыг баталгаажуулах, дүрст дүн шинжилгээ хийх, генетикийн шүүх шинжилгээ, хордолтын шүүх шинжилгээтэй холбоотой ажиллагаануудыг үе шаттай хэрэглэж эхэлсэн юм. 1992 он гэхэд эдгээр үйл ажиллагаанууд жигдэрч шинжээч мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр хөлсөөр ажиллуулах тогтолцоо бий болгосон төдийгүй өөрийн гэсэн шинжилгээний лабораторийг байгуулсан байна.

2008 онд Солонгос улсын Прокурорын ерөнхий газар нарийн төвөгтэй, ээдрээтэй гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор “Үндэсний дижитал шүүх шинжилгээний төв”-ийг байгуулсан. Энэхүү төв нь олон төрөлд хуваагдсан шинжлэх ухааны шүүх шинжилгээний /scientific investigation/ тогтолцоог нэгдмэл байдалд оруулж мэргэшсэн ажилчдын тоог өсгөх, тэнхимүүдийг өргөтгөх болон шинжилгээний шинэ тоног төхөөрөмж нэвтрүүлэх зорилгоор байгуулагдсан байна. НДФС-ийн үйл ажиллагаа ерөнхийдөө прокуроруудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх юм. Үүнд аливаа мэдээллийг нөхөн сэргээх, түүнд дүн шинжилгээ хийх, цахилгаан утсанд дүн шинжилгээ хийх, и-мэйл болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, мэдээлэл технологийн/IT/ хөгжлийг ашиглан төрөл бүрийн нууцлалтай код тайлах зэрэг үйл ажиллагаа багтана. Прокурорын ерөнхий газар өөрсдийн салбар болох дүүргийн прокурорын газруудад нийт 7 Дижитал шүүх шинжилгээний багийг бий болгон ажиллуулж байна. Одоогоор нийт 120 гаруй шүүх шинжилгээний мэргэжилтнүүд Прокурорын ерөнхий газарт харьяалагдан ажилладаг байна.

⁷⁴<http://www.mayoclinic.org/tests-procedures/eeg/basics/definition/prc-20014093>

⁷⁵https://books.google.mn/books?id=GvRMBgAAQBAJ&pg=PA193&lpg=PA193&dq=forensic+science+in+Korea+research&source=bl&ots=ojY9UuYp4_&sig=Ndf0dbIJXEPxmvzQHrOHv2ZbgCk&hl=en&sa=X&ei=gnBRVYTSNJXYoASSq4HoCw&ved=0CDEQ6AEwAw#v=onepage&q=forensic%20science%20in%20Korea%20research&f=false

НДФС-нь дараах⁷⁶шүүх шинжилгээний чиглэлээр дагнан салбарлаж, дор дурдсан чиг үүргийн хүрээнд шүүх шинжилгээ хийж гүйцэтгэдэг байна. Үүнд:

Салбар	Чиг үүрэг
Шүүх шинжилгээ (1)	Тус газар нь шинжлэх ухааны зарчимд тулгуурласан мөрдөн байцаалт, дүн шинжилгээний техник, тоног төхөөрөмж дээр үндэслэсэн судалгаагаар дамжуулж мөрдөн байцаалтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Мөн түүнчлэн шүүх шинжилгээний хэрэгт холбогдсон баримт бичгийн хяналт, шалгалт, дүрс зураг, дуу авианы дүн шинжилгээ, мэдээллийн хэрэгслүүдийг нөхөн сэргээх, галын мөрдөн шалгах ажиллагаа, сэтгэл судлалын тест авах, хувийн зан байдал болон мэдүүлэгт дүн шинжилгээ хийх, сэтгэл зүйн клиник үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагаануудыг явуулдаг.
Шүүх шинжилгээ(2)	Энэхүү газар нь шүүхийн химийн шинжилгээний нэг хэсэг болох хоол хүнс, эмчилгээ, хүчтэй химийн бодис болон мансууруулах бодис гэх зэрэг төрлөөр дүн шинжилгээ хийдэг. Мөн түүнчлэн ДНХ-ын дүн шинжилгээ, шүүх биологийн дүн шинжилгээгээр дамжуулан гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх ач холбогдол бүхий мэдээ мэдээлэл, нотлох баримтаар хангах үйл ажиллагаа явуулдаг байна.
Дижитал шүүхшинжилгээ	Дижитал шинжилгээний газар нь аж ахуйн нэгж /компани/ болон албанбайгууллагуудын системд мэдээллийн дүн шинжилгээ хийх, гадаад хатуу диск, утасны төхөөрөмж, компьютер гэх зэрэг тоон төхөөрөмж бүхий нотлох баримтыг нөхөн сэргээх, дүн шинжилгээ хийх, цуглуулах гэх зэрэг үйл ажиллагаагаар шүүх шинжилгээний туслалцаа үзүүлдэг байна.
Цахим гэмт хэргийн мөрдөн байцаалт	Тус газар нь цахилгаан шүлжээ, протокол, код зэрэгт дүн шинжилгээ хийх замаар цахим гэмт хэргийг илрүүлэх, цахим гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах болон холбогдох хууль тогтоомжид санал өгөх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна. Өөрөөр хэлбэл цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх замаар дотоод болон гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлдэг. Хамтран ажилладаг байгууллагуудын тусламжтайгаар цахим халдлагатай тэмцэх, цахим гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаалтын

⁷⁶<http://www.spo.go.kr/eng/about/sic.jsp>

ажиллагаа явуулах зэрэг ажил үүргийг хариуцдаг байна.

Цэ
ргий

**н шүүх шинжилгээ, Үндэсний батлан хамгаалах яамны харьяа Шинжлэх ухааны шүүх шинжилгээний хүрээлэн
/Institute of scientific investigation/**

Энэхүү байгууллага нь анх 1953 онд цэрэг, батлан хамгаалах салбарын “Цэргийн цагдаагийн газрын/Military Police Department/ судалгаа, шинжилгээний Төв” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. 1987 оноос эхлэн Үндэсний батлан хамгаалах яамны харьяандшинэчлэгдэн байгуулагдсанаар шинжлэх ухааны шүүх шинжилгээний үйл ажиллагааны хүрээ, чиг үүргээ өргөжүүлсэн юм. Энэ хүрээнд шинжлэх ухааны шүүх шинжилгээнд техникийн туслалцаа үзүүлэх, нотлох баримтанд шүүх шинжилгээний тест явуулах, тоног төхөөрөмжийг ажиллуулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байсан байна. Тус хүрээлэн нь өнөөдрийн байдлаар анагаах ухааны шүүх шинжилгээ/forensic medical/, химийн шүүх шинжилгээ ба баримт бичгийн дүн шинжилгээ, тэсрэх, дэлбэрэх болон галдан шатаахтай тэмцэх баг болон полиграфын шинжилгээ зэрэг олон төрлийн шинжилгээ хийхбүтэц зохион байгуулттай ажиллаж байна. Ялангуяа шүүх шинжилгээний генетикийн салбарт Солонгосын дайнаас үүдсэн цогцосыг ДНХ-ийн дүн шинжилгээ хийх замаар таних гэх зэрэг ажлыг явуулдагаараа нэр хүндтэй байдаг байна.

Солонгосын эргийн хамгаалалтын судалгааны хүрээлэн

Солонгосын эргийн хамгаалалтын газар нь 2010 онд өөрийн судалгааны хүрээлэнтэй болж “Эргийн хамгаалалтын судалгаа хөгжлийн төв”-ийг үүсгэн байгуулсан. Тус төвийн үндсэн үүрэг нь далайн хүрээлэн буй орчныг сайжруулах зорилгоор судалгаа шинжилгээний ажил хийх зэргээр Эргийн хамгаалалтын газрын ажилд дэмжлэг үзүүлэх явдал юм. Мөн далайн гэмт хэргийг илрүүлэх, шинжлэх ухааны шүүх шинжилгээ хийх, тоног төхөөрөмжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, далайн усны бохирдлын түвшинг тогтоох, далайн хог хаягдлыг хянах замаар түүнтэй тэмцэх төлөвлөгөө боловсруулах болон бохирдуулагч бодист дүн шинжилгээ хийх ажиллагаануудыг гүйцэтгэж байна⁷⁷.

Прокурорын Ерөнхий газар болон Цагдаагийн байгууллага нь дээр танилцуулсаншүүх шинжилгээний болон мөрдөн шалгах байгууллагуудыг өөрсдийн харьяалах чиг үүрэгт холбогдох асуудлаар удирдах системтэй байдаг юм. Түүнчлэн шүүх шинжилгээ хийх арга зам, туршлага нэвтрүүлэх болон түүний сургалттай холбоотой асуудлаар хуулийн байгууллага, сургуулиудтай хамтран үйл ажиллагаа явуулдаг байна.

3.2.2 Шүүх шинжилгээний өнөөгийн нөхцөл байдал

Өнөөдөр Солонгос улсад шүүх шинжилгээтэй холбоотой гол үйл ажиллагааг явуулж байгаа байгууллага НФС болон НДФС юм. 2012 ондНФС 298729,НДФС 87943 гаруй шинжилгээ хийсэн гэсэн тоо баримт байдаг. НФС-ийн хувьд шүүх шинжилгээ хийсэн тоо баримт нь жил ирэх тусам өсч байгаа. Жишээлбэл 2012 онд 5150 хэрэгт цогцост задлан

⁷⁷https://books.google.mn/books?id=GvRMBgAAQBAJ&pg=PA193&lpg=PA193&dq=forensic+science+in+Korea+research&source=bl&ots=ojY9UuYp4_&sig=Ndf0dbJXEPxmvzQHrOHv2ZbgCk&hl=en&sa=X&eignBRVYTSNJXYoASSq4HoCw&ved=0CDEQ6AEwAw#v=onepage&q=forensic%20science%20in%20Korea%20research&f=false

шинжилгээ, 104165 ДНХ-ийн шинжилгээ, 61132 мансуурах болон хордуулах бодисын шинжилгээ, 17371 инженерийн шүүх шинжилгээ, 14183 баримт бичиг, дүрсийн шинжилгээ, 536 хэрэгт сэтгэл судлалын шинжилгээ, 35878 согтууруулах ундааны, нотлох баримтын ул мөрийн болон бусад шүүх шинжилгээний ажил гүйцэтгэсэн байна. 2010 оны 9 сараас эхлэн НФС болон НДФСхамтран хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч болон гэмт хэргийн нотлох баримтыг хадаглах мэдээллийн нэгдсэн сан байгуулсан байна. Шинээр байгуулагдсан нэгдсэн санд анх нийт 36010 хэргийн материалыг байршуулсан бөгөөд үүнээс хойш тус сан гэмт хэрэгт сэжиглэгдэн хоригдож байсан этгээдийн 23755 гаруй хэргийн мэдээлэл болон яллагдагч этгээдтэй холбоотой нийт 45789 гаруй мэдээллийг агуулсан томоохон мэдээллийн сан болж өргөжсөн байна⁷⁸.

3.2.3 Шинжээч, албан хаагчдын эрх зүйн байдлын зохицуулалт

Солонгос улсын аль нэг шүүх шинжилгээний байгууллагад ажиллах хүсэлтэй тохиолдолд шинжээчийн мэргэжлийн сургууль төгсөх шаардлага тавигддаг байна. Мэргэжил эзэмшсэний дараа шинжээчийн үнэмлэх авснаар шинжээч болох эрх нээгддэг. Шинжээчмэргэжилтэн бэлтгэдэг хэд хэдэн сургууль байдаг бөгөөд магистрын түвшний сургалт явуулдаг байна. Эдгээр сургуулиудад шүүх эмнэлэгийн шинжээч, биологийн шинжээч /ДНХ/, гэмт хэргийн сэтгэл судлалын шинжээч, мансууруулах эм, хор судлалын шинжээч, мансууруулах бодисын шинжилгээний шинжээч, химийн шинжилгээний шинжээч, физикийн шинжилгээний шинжээч, зам, тээврийн шинжилгээний шинжээч гэсэн чиглэлээр мэргэшүүлэн шинжээчийн үнэмлэх олгодог⁷⁹. Дээрхи мэргэжил эзэмшсэн шинжээчид жам ёсны бус үхэл, араг ясны шинжилгээ, цусны бүлэг, ДНХ-ээр хүмүүсийг олж тодорхойлох, полиграфын шинжилгээ, бичгийн хэлбэр болон хүний дүр төрхийг шинжлэх, зураг дүрсээр шинжлэх, эм, хорны шинжилгээ, мансууруулах бодисын шинжилгээ, микро хэмжээний нотлох баримтыг судлах, галын шинжилгээ, галт зэвсэг, тэсрэх бодисын шинжилгээ, дуу, авианы шинжилгээ, зам тээврийн ослын шинжилгээ, хурууны хээний шинжилгээ гэсэн ерөнхий төрөл ангилалын хүрээнд нарийн мэргэжлийн шинжилгээнүүдийг өөр өөрийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн шүүх шинжилгээний байгууллагуудад гүйцэтгэдэг байна.

3.2.4 Дүгнэлт

Солонгос улсын шүүх шинжилгээний байгууллага анх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдаж байсан бол одоо цагдаагийн, прокурорын, эргийн хамгаалалтын газрын дэргэд тухайн байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбогдох судалгаа, шинжилгээний ажил хийж гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагууд болон өргөжин тэлсэн байна. Солонгос улс дахь шүүх шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаа нь зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх, нотлох баримтыг бэхжүүлэх, түүнд шинжилгээ хийж дүгнэлт, магадлагаа гаргах замаар шүүх, цагдаа, прокурорын ажлыг дэмжихэд оршдоггүй байна. Өмнө танилцуулсан шинжилгээний байгууллагууд бүгд шинжлэн магадлах ажиллагааны зэрэгцээ шинийг эрэлхийлсэн эрдэм шинжилгээний судалгаа

⁷⁸https://books.google.mn/books?id=GvRMBgAAQBAJ&pg=PA193&lpg=PA193&dq=forensic+science+in+Korea+research&source=bl&ots=ojY9UuYp4_&sig=Ndf0dbIJXEPxmvzQHrOHv2ZbgCk&hl=en&sa=X&ei=gnBRVYTSNJXYoASSq4HoCw&ved=0CDEQ6AEwAw#v=onepage&q=forensic%20science%20in%20Korea%20research&f=false

⁷⁹http://kin.naver.com/qna/detail.nhn?d1id=1&dirId=11004&docId=213522909&qb=7Y+s66CM7ludlOu2hOyEnQ==&enc=utf8§ion=kin&rank=2&search_sort=0&spq=0&pid=SScU%2BsoRR0CssZcFUQKsssssss-140987&sid=h2NnzKLTH7awyQCdwp8FpA%3D%3D

шинжилгээ хийх үүрэг хүлээсэн байгаа нь онцлог юм. Мөн эдгээр шинэ арга зүй, туршилтыг өөрсдийн лабораториудад хэрэгжүүлэхээс гадна бусад хууль, хяналтын байгууллагын алба хаагч, хуулийн болон цэргийн сургуулиудтай хамтарсан сургалт зохион байгуулах замаар таниулж, сурталчилж байгаа нь шинэ техник, технологи, арга зүйг хурдан шуурхай нэвтрүүлэхэд чухал үүрэг, нөлөө бүхий байгууллага болгож байна. Ийнхүү шүүх шинжилгээний байгууллагууд өөр өөрийн салбар, чиглэлээр тусгайлан мэргэшиж байгаа нь шүүх шинжилгээний аль нэг төрлөөр өндөр түвшинд хөгжих, өргөжин тэлэх боломжийг олгохоос гадна тухайн байгууллагаас гаргасан дүгнэлт, магадлагаа гарцаагүй, баталгаатай байх үндэслэл болж байдаг байна. Тухайлбал Үндэсний батлан хамгаалах яамны харьяа Шинжлэх ухааны шүүх шинжилгээний хүрээлэнд Солонгосын дайнаас үүдсэн цогцост ДНХ-ийн дүн шинжилгээ хийж мэргэшсэн нь тухайн байгууллагыг ДНХ-ийн төрлийн шинжилгээгээр мэргэшүүлж байдгаараа онцлон байна.

Солонгосын шүүх шинжилгээний байгууллагуудын дийлэнхи нь улсын төсөв болон үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоороо санхүүждэг. Эдгээр шинжилгээний байгууллагууд хэдийгээр бүгд өөр өөр байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулдаг хэдий ч нэгдсэн мэдээллийн сан болон салбар бүхэн өөрийн харьяалах асуудлын хүрээнд мэдээлэл солилцох боломжоор хангагдсан байдаг байна.

Солонгос улсын шүүх шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг, алба хаагчдийн эрх зүйн байдлын талаар судлах явцад шүүх төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий шүүх шинжилгээний төв байгууллагатай бөгөөд бусад хууль, хяналтын төрийн байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд төв, хүрээлэн хэлбэрээр шүүх шинжилгээний зэрэгцээ эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажил давхар гүйцэтгэдэг байгууллагатай байх нь түгээмэл байна. Ингэснээр тухайн хүрээлэн/төвийн шинжээчид өөрийн харьяалагдаж буй салбарын үйл ажиллагааны чиглэлээр дагнасан судалгаа шинжилгээний ажлаар гоц мэргэшэх боломжтой бүрэлддэг байна. Эдгээр шинжилгээний хүрээлэн/төвүүд олон улсын стандартад нийцсэн шүүх шинжилгээний үр дүн буюу дүгнэлт, магадлагаа гаргахыг зорилго болгон ажилладаг бөгөөд үүний тулд олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, шинэ техник технологи хөгжүүлэх, нэвтрүүлэх, шинжээч мэргэжилнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг байна.

Солонгос улсын шүүх шинжилгээний байгууллагын үүсэл хөгжил нь манай улсын шүүх шинжилгээний байгууллагын үүсэл хөгжилтэй нэгэн адил цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдсан байна. Судалгааны ажлын хүрээнд Солонгосын шинжээч мэргэжилтнүүд цагдаагийн цол авдаг эсэх талаар судлахыг хичээсэн боловч энэ тухай тодорхой мэдээлэл олдоогүй болно. Харин шинжээч болохын тулд шүүх шинжилгээний шинжээчийн сургалтад хамрагдаж магистрын зэрэгтэй, шинжээчийн гэрчилгээтэй байх гэсэн шаардлага тавигддаг байна.

3.3 ЭСТОНИ УЛСЫН ТУРШЛАГА

3.3.1 Шүүх шинжилгээний асуудал хариуцсан төрийн эрх бүхий байгууллага, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт

Шүүх шинжилгээний асуудал хариуцсан төрийн эрх бүхий байгууллага гэдэгт шүүх шинжилгээ хийх үйл ажиллагааны үндсэн зорилготой төрийн байгууллагыг ойлгоно. Тус байгууллагын дүрмийг Хууль зүйн сайдын тушаалаар тогтоох⁸⁰ бөгөөд Хууль зүйн яамны

⁸⁰Forensic Examination Act, Art.8.1

харьяанд үйл ажиллагаа явуулна. Шинжилгээний байгууллагын жагсаалт, тэдгээрт ажиллаж байгаа шинжээчдийн цалингийн зэрэглэлийг Засгийн газар батална.⁸¹Шүүх шинжилгээ хийх байгууллага нь дараах төрлийн шинжилгээ хийнэ. Үүнд:

1. Шүүх эм зүйн шинжилгээ;
2. Шүүх биологийн шинжилгээ;
3. Шүүх химийн шинжилгээ;
4. Шүүх антропологийн шинжилгээ;
5. Шүүх шинжилгээний байгууллагын дүрэмд заасан бусад шинжилгээ.⁸²

Шүүх шинжилгээний асуудал хариуцсан төрийн эрх бүхий байгууллага нь Эстонийн Шүүх шинжилгээний хүрээлэн байна. Тус хүрээлэнг Эстонийн Шүүхийн эм зүйн товчоо болон Шүүхийн Үйлчилгээний албыг нэгтгэж 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан. Эрх барих дээд байгууллага нь 5 гишүүнтэй хяналтын зөвлөл юм.⁸³Хүрээлэнгийн бүтцийг Засгийн газрын тухай хуулийн 43 (5), Шүүх шинжилгээний тухай хуулийн 301 (1), (2) зүйлүүдэд үндэслэн Хуулийн сайдын тушаалын хавсралтаар баталсан⁸⁴ (байгууллагын бүтцийг хүснэгтээс үзнэ үү).

Санхүүжилт. Санхүүгийн үндсэн эх үүсвэр нь улсын төсөв байх ба Хууль зүйн сайдын багцаас санхүүжинэ. Мөн шүүх шинжилгээний үйлчилгээг хувь этгээдүүдэд төлбөртэйгээр хийснээс олсон орлого санхүүжилтийн нэг эх үүсвэр байж болно. Үүнд хувь хүний захиалгаар хийж байгаа эцэг тогтоох шинжилгээ, хорын шинжилгээ, бичгийн хэлбэр судлах, электрон микрософийн шинжилгээ зэрэг орно⁸⁵.

⁸¹Forensic Examination Act, Art.8.3


⁸²Forensic Examination Act, Art.9(1)

⁸³<http://www.ekei.ee/en/efsi-organization> as official site of the Estonian Forensic Science Institute. Сүүлд үзсэн огноо: 2015.05:19

⁸⁴<http://www.ekei.ee/en/efsi-organisation/organization>. Сүүлд үзсэн огноо: 2015.05:19

⁸⁵Douglas H. Ubelaker, *The Global Practice of Forensic Science*, 2015, p.93

Эстониин Шүүх шинжилгээний хүрээлэнгийн бүтэц



3.3.2 Шинжээчийн эрх зүйн байдлын зохицуулалт

Шинжээч нь эрх зүйн байдлын хувьдотроо 2 янз байна. Эхнийх нь шүүхийн шинжээч (*forensic expert*), удаах нь албан ёсоор гэрчилгээ авсан шинжээч (*officially certified expert*) юм. Шүүхийн шинжээчээр ажиллах этгээд нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Эрх зүйн чадамжтай байх;
2. Эстони хэлний өндөр түвшний чадвартай байх;
3. Эстони улсын дээд боловсролын байгууллагад өөрийн мэргэшсэн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэнбайх;
4. Шинжээчээр ажиллаж эхлэхээсээ өмнө доод тал нь 2 жил шүүх шинжилгээний эсхүл судалгааны байгууллагад мэргэшсэн чиглэлээрээ ажилласан байх.⁸⁶

Дараах этгээдийг шүүхийн шинжээчээр ажиллахыг хориглоно. Үүнд:

1. Гэмт хэрэг санаатай үйлдэж яллагдсан;
2. Авилгын эсрэг хуульд заасан зөрчилд шийтгэгдсэн;
3. Албан тушаалын хувьд шууд харьяалагдах ажил олгогч болон хянагчтай цусан төрлийн (өвөө, эмээ, эцэг эх, ах, эгч, хүүхэд, ач, зээ) болон гэрлэлтээр холбогдсон (эхнэр, нөхөр болон эхнэр, нөхрийн эцэг эх, ах, эгч, хүүхэд) харилцаатай;
4. Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан шинжээчийн ажил хийх боломжгүй.⁸⁷

Шүүх шинжээч хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ба ийнхүү хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа ажил олгогчийн өмнө дараах агуулга бүхий тангараг өргөнө. Үүнд “...*Миний бие өөрийн эзэмшсэн тусгай мэдлэг чадвар, ухамсараа удирдлага болгон шүүхийн шинжээчийн үүргээ шударгаар гүйцэтгэж шинжээчийн дүгнэлтээ хараат бус хөндлөнгийн байр сууринаас гаргахаа тангараглаж байна. Худал шинжээчийн дүгнэлт гаргасан тохиолдолд Эрүүгийн хуулийн 321 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээхээ ухамсарлаж байна.*”⁸⁸ гэж хэлнэ. Шүүхийн шинжээч тангарагт гарын үсэг зурж, тангараг өргөсөн огноог тэмдэглэнэ. Тангаргийн гарын үсэг зурсан эх бичвэрт ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээг хавсаргана.⁸⁹

Албан ёсоор гэрчилгээ авсан шинжээч нь албан ёсоор гэрчлэгдсэн шинжээчдийн жагсаалтад орсон этгээд байна. Жагсаалтыг Засгийн газар эсхүл Засгийн газрын эрх бүхий сайд батлахаар хуульд заасан.⁹⁰ Практикт ихэнх тохиолдолд Хууль зүйн сайд баталдаг. Ийм этгээд нь эрх зүйн чадамжтай, Эстони хэлний өндөр түвшний чадвартай байх, Эстони улсын дээд боловсролын байгууллагад өөрийн мэргэшсэн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэнбайх, гэмт хэрэг санаатай үйлдэж яллагдаж байгаагүй, Авилгын эсрэг хуульд заасан зөрчилд шийтгэгдээгүй байна. Эдгээр шаардлагад нийцсэний дараагаар дараах урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд жагсаалтад орох боломжтой. Үүнд:

1. Жагсаалтад орох тухай өргөдөл гаргахаас өмнө мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
2. Шинжилгээ судалгаа хийхэд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах боломжтой байх;
3. Байнгын орлоготой байх.⁹¹

⁸⁶Forensic Examination Act, Art.6.1

⁸⁷Forensic Examination Act, Art.6.2

⁸⁸Forensic Examination Act, Art.7.1

⁸⁹Forensic Examination Act, Art.7.2

⁹⁰Forensic Examination Act, Art.11(5)

⁹¹Forensic Examination Act, Art.12(1)

Шүүхийн шинжээчээр ажиллаж байгаа этгээд нь албан ёсоор гэрчлэгдсэн шинжээчдийн жагсаалтад орж болохгүй. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа этгээд нь шинжилгээ хийх үедээ хөдөлмөрийн гэрээний үүргээсээ чөлөөлөгдсөн тохиолдолд жагсаалтад орж болох бөгөөд албан ёсоор гэрчилгээ авсан шинжээч нь хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллана. Жагсаалтад орсон шинжээчдэд 3 жилийн хугацаатай гэрчилгээ олгоно. Гэрчилгээг шүүх шинжилгээний асуудал хариуцсан төрийн эрх бүхий байгууллага болох Эстонийн Шүүх шинжилгээний хүрээлэн олгоно. Гэрчилгээний хугацаа нь тухайн шинжээчийг жагсаалтад орсноос хойших 3 дахь жилийн 12 дугаар сарын 15-ны өдөр дуусгавар болно.⁹² Гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусгавар болохоос 3 сарын өмнө гэрчилгээг сунгах тухай хүсэлтийг шүүх шинжилгээний асуудал хариуцсан төрийн эрх бүхий байгууллагад гаргах⁹³ ба мөн 3 жилийн хугацаагаар сунгана.⁹⁴

Шинжээчийн нийтлэг эрх, үүрэг

Шинжилгээ хийх үедээ шинжээч нь процессын хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Мөн шинжилгээ хийж байх үед түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй бие бүрэлдэхүүний үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх; шинжилгээний үеэр цугларсан мэдээллийг хадгалах; шүүх шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийсэн тохиолдолд шинжээчийн тайлан гаргаж дууссанаас хойш 10 хоногийн дотор тайлангийн нэг хувийг холбогдох хавсралтын хамтаар шүүх шинжилгээний байгууллагад хүргүүлэх зэрэг үүрэгтэй.⁹⁵

3.3.3 Хууль тогтоомж

2002 онд баталсан Шүүх шинжилгээний тухай хууль (*Forensic Examination Act*) нь энэ салбарын гол эрх зүйн эх сурвалж юм. Тус хуулиар шүүхийн шинжээч, улсын шүүх шинжилгээний институци болон албан ёсоор гэрчилгээ олгогдсон шинжээчийн эрх зүйн байдал, эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шинжээчийн эдлэх эрх, хүлээх үүрэг үүсэх үндэслэл зэргийг зохицуулсан байна. Нийт 6 бүлэг, 30 зүйлтэй. Тус хуульд “**шүүх шинжилгээ** гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр томилогдсон этгээдийн шинжээчийн үүрэг даалгавартаа үндэслэн гаргасан материалыг судалж шинжлэх ухаанчаар дүгнэлт гаргахад чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа юм”⁹⁶ хэмээн тодорхойлсон байна. Шинжээчийн дүгнэлт гэдэгт нотлох үүрэгтэй холбогдсон фактыг бүрдүүлж байгаа болон шинжээчийн тайланд илэрхийлсэн категорчилсан, үндэслэл бүхий шинжээчийн шийдвэрийг ойлгоно⁹⁷. Мөн эрүү, иргэн болон захиргааны процессын тухай хуулиудаар шинжээчийн эрх, үүргийн асуудлыг зохицуулсан.

3.3.4 Дүгнэлт

Эстони улсад шүүх шинжилгээний байгууллага нь Хууль зүйн яамны харьяанд улсын төсвөөс санхүүжин үйл ажиллагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл шүүх шинжилгээ явуулах эрх мэдэл, институци нь төрд хадгалагдах бөгөөд төрөөс бусад этгээд (хувь этгээд) ийм үйл

⁹²Forensic Examination Act, Art.18(1),(2)

⁹³Forensic Examination Act, Art.18(4)

⁹⁴Forensic Examination Act, Art.18(3)

⁹⁵Forensic Examination Act, Art.23(2)

⁹⁶Forensic Examination Act, Art.2. This law is available at www.riigiteataja.ee/en/eli/521042014001/consolide.

⁹⁷Forensic Examination Act, Art.3

ажиллагаа явуулах боломжгүй. Товчхондоо хувийн шүүх шинжилгээний байгууллагыг хориглодог. Шүүх шинжилгээний тухай хуульд тодорхойлсноор шүүх шинжилгээний байгууллага нь шүүх эм зүйн шинжилгээ; шүүхбиологийн шинжилгээ; шүүх химийн шинжилгээ; шүүхантропологиин шинжилгээ зэрэг олон төрлийн цогц шинжилгээ явуулах зохицуулалттай. Үүнээс харахад шүүх шинжилгээний байгууллагыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх дэд салбар бус бие даасан шинжлэх ухаан байдлаар авч үзэж байна гэж дүгнэж болох юм.

Шинжээчийн хувьд шүүх шинжилгээний байгууллагад хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилладаг байнгын ажлын байр бүхий шүүх шинжээч, шаардлагатай тохиолдолд хөлсөөр ажилладаг, эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад бүртгэгдэж тодорхой хугацаатайгаар гэрчилгээ авдаг шинжээч гэсэн 2 төрөл байна. Тэдгээр нь цагдаагийн байгууллагын бүтцэд хамаарахгүйгээр нэг талаас цагдаагийн байгууллагын гэмт хэрэг илрүүлэх, ул мөр тогтоох, таних ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас эрх зүйн процессийн ажиллагаа (хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа)-нд өөрийн гэсэн эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээн бие даан оролцдог.

Үндсэндээ Эстони улс нь бидний өмнөх хэсэгт тодорхойлсон forensic science буюу шүүх шинжилгээг өргөн хүрээнд авч үздэг хандлагад хамаарч байна.

3.4 АВСТРАЛИ УЛС

3.4.1 Шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, санхүүжилт

Австрали улс шүүх шинжилгээний институци өргөн хүрээнд тархсан бүтэцтэй болох нь олон тооны орон нутгийн болон бүс нутаг хамарсан гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий (цагдаагийн) байгууллага бүр өөрийн гэсэн шүүх шинжилгээ явуулах аппарат, чадавхтай байдгаар илэрдэг байна. Гэхдээ шүүх шинжилгээний институцийн үйл ажиллагааг бүхэлд нь нэгтгэн зангиддаг байгууллага нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн (National Institute of Forensic Science) юм. Австрали (мөн Шинэ Зеланд)-д шүүх шинжилгээний үндсэн үйл ажиллагааг төрийн эрх мэдлийн хүрээнд төрийн байгууллагуудаас явуулах бөгөөд ийм чиг үүрэгтэй байгууллага нь засгийн газрын бүтцэд түүний харьяа агентлаг, газрын статустай байх шаардлагагүй гэж үздэг байна.⁹⁸

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн (National Institute of Forensic Science). Тус хүрээлэн нь анх 1991 онд Австралийн Цагдаагийн газрын дэргэд сайд нарын зөвлөлийн гэрээний дагуу Үндэсний Нийтийн цагдаагийн алба гэсэн нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1992 оны 2 дугаар сард үйл ажиллагаагаа эхэлсэн. 2008 оноос хойш хүрээлэн нь Австрали Шинэ Зеландын Цагдаагийн үйл ажиллагаанд зөвлөх агентлаг (*Australia New Zealand Policing Advisory Agency*)-ийн захиргааны үүрэг гүйцэтгэх болсон байна.⁹⁹ Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн нь энэ байгууллагын захиргааны үүрэг гүйцэтгэх болсноор дараах бүтэцтэй болжээ. Санхүүгийн үндсэн эх үүсвэр нь улсын төсөв байна.

Австралийн шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн

⁹⁸Ross, Alastair, Forensic Science in Australia: Where does Australia sit in relation to Trends and Issues in the International Context?, Current Issues in Criminal Justice, Volume 24/No.1. This comment is available at <http://www.austlii.edu.au/au/journals/CICrimJust/2012/23.html>.

⁹⁹<https://www.anzpa.org.au/forensic-science/10636>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.27.



Австрали, Шинэ Зеландын Цагдаагийн үйл ажиллагаанд зөвлөх агентлаг нь Австрали, Шинэ Зеландын Цагдаагийн Комиссаруудын газар (the Australian and New Zealand Police Commissioners)-ын санаачлагаар байгуулагдсан. Дараах чиг үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Шүүх шинжилгээний чиглэлээрх судалгааны ажлыг санхүүжүүлэх, дэмжих;
2. Шүүх шинжилгээний үйлчилгээг хөгжүүлэх болон зохицуулан холбох асуудлаар зөвлөх, туслалцаа үзүүлэх;
3. Шүүх шинжилгээний талаарх мэдээлэл олох, солилцох;
4. Шүүх шинжилгээний чиглэлийн сургалтад дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлийн сургалтыг зохицуулан холбох, зохион байгуулах гэх мэт.

Хоёр дахь шүүх шинжилгээний голлох институци нь Австралийн Холбооны цагдаагийн газрын шүүх шинжилгээний болон мэдээллийн төвүүд (*Australian Federal Police's Forensic and Data Centres*) юм. Эдгээр төв нь дэлхийд жишиг болсон үйлчилгээ (world-class service)-г цаг алдалгүй, хараат бус, үйлчлүүлэгчдээ тулгуурласан хандлагаар үзүүлдэг байна.¹⁰⁰ Үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу шүүх шинжилгээний, мэдээллийн гэсэн 2 хэсэгт хуваагдана.

Шүүх шинжилгээний үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна. Үүнд:

1. Зэвсгийн шинжилгээ;
2. Хэргийн газрын шинжилгээ;
3. Гарын хурууны хээний шинжилгээ;
4. Хэргийн газраас олдсон эд зүйлийн шинжилгээ;
5. Тээврийн хэрэгслийн хяналт шинжилгээ;
6. Галт зэвсгийг танин тогтоох ажиллагаа;
7. Биологийн криминалистик;
8. Химийн криминалистик;
9. Баримт бичгийн шинжилгээ;
10. Дижитал шүүх шинжилгээ;
11. Аудио, видеог сайжруулах;
12. Ослын хохирогчийг таних гэх мэт.

Эдгээр шүүх шинжилгээний үйлчилгээ явуулах эрхийг өмнөх хүснэгтэд дурдсан Туршилт, шинжилгээний асуудал хариуцсан үндэсний холбоо (National Association of Testing Authorities) магадлан итгэмжилнэ.

Санхүүжилт. Хамгийн сүүлд олдсон мэдээллээр буюу 2013-2014 оны байдлаар Австралийн Холбооны Цагдаагийн газар нийт 1, 364, 000, 000 долларын санхүүжилт хүлээн авсны 286,075,000 долларыг Шүүх шинжилгээ, мэдээллийн төвүүдийг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.¹⁰¹ Эндээс харахад төсвийн хувьд төрөөс хамааралтай байна.

3.4.2 Шинжээч, албан хаагчдын эрх зүйн байдал

Австрали улсад шүүх шинжээчийг тодорхой салбараар мэргэших байдлаар их сургуулийн боловсролоор тусгайлан бэлтгэдэг байна. Шүүх шинжээч нь дотроо хэдэн янз байна (доорх жагсаалт бүрэн биш болно). Үүнд:

¹⁰⁰<http://www.afp.gov.au/what-we-do/operational-support/forensic-and-data-centres>. Last visited on 27 May 2015

¹⁰¹<https://www.ag.gov.au/Publications/Budgets/Budget2013-14/Documents/PBS%202013-14%20AFP.PDF>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.27.

- a) Шүүх патологист - хүн амиа хорлосон болон бусдын гарт амь насаа алдсан /гадны нөлөөгөөр нас барсан тохиолдолд нас барсан цаг хугацаа, шалтгааныг тодорхойлох;
- b) Шүүх онтологист – гол төлөв зөвлөх байдлаар ажилладагшүүх шүд судлаач;
- c) Шүүх хүн судлаач – онгоцны осол, тэсрэлт, дэлбэрэлт, гал түймэрийн улсаас нас барсан хүнийг таних;
- d) Шүүх психологич – гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөхцөлийг харилцан ярилцах байдлаар тогтоох;
- e) Шүүх анагаахын клиникийн шинжээч – гэмт хэргийн хохирогч болон гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хэмээн сэжиглэж байгаа этгээдийг шалган тогтооох;
- f) Шүүх ийлдэс шинжээч – цусны бүлэг, цус болон бусад биеийн шингэн эд, ДНХ, гарын хурууны хээ зэргийг шинжлэх;
- g) Шүүх химич – хориотой бодис, галдан шатаасан тохиолдлуудад катализатор, тэслэгч бодис, галт зэвсэг, ул мөрт нотлох баримт зэргийг таних, илрүүлэх;
- h) Шүүх хэл зүйч -хүүхэд хулгайлах зэрэг гэмт хэрэгт гэмт этгээдийг таних, бичгийн болон амаар өгсөн ярилцлагад дүн шинжилгээ хийх;
- i) Шүүх инженер – зам тээврийн осол, гал түймэрийн шалтгааныг тогтоох.

Хэд хэдэн их сургуульдшүүх шинжээчийн бакалаврын болон магистрын, түүнээс дээш түвшний зэрэг олгодог байна. Үүнд:

Төв Күйнсландын их сургууль (Central Queensland University)-дшүүх хими судлалын чиглэлээр 3 жилийн хугацаатай бакалаврын зэрэг¹⁰², Викториагийн их сургуульдшүүх болон аналитик хими судлалын чиглэлээр 3 жилийн хугацаатай суралцах бакалаврын зэрэг¹⁰³, Күйнсландын технологийн их сургууль шүүх шинжилгээний чиглэлээр 3 жилийн хугацаатай бакалаврын зэрэг¹⁰⁴, Дийкэний их сургууль (Deakin University) шүүх шинжилгээний чиглэлээр 4 жилийн хугацаатай суралцах бакалаврын зэрэг¹⁰⁵, Куртины Технологийн их сургууль шүүх шинжилгээний чиглэлээр 4 жилийн хугацаатай суралцах бакалаврын зэрэг¹⁰⁶, Флиндерсийн их сургууль шүүх болон аналитик химийн чиглэлээр 3 жилийн хугацаатай суралцах бакалаврын зэрэг¹⁰⁷, Ньюкастлийн их сургууль шүүх шинжилгээний чиглэлээр бакалаврын зэрэг¹⁰⁸ тус тус санал болгодог бол Гриффитын их сургууль шүүх психологи, шүүх остеологи, (ерөнхий) шүүх шинжилгээний чиглэлүүдээр магистрын зэрэг олгодог байна.¹⁰⁹Мөн Ла Тробегийн их сургууль¹¹⁰, Монашын их сургууль¹¹¹, Мелбурны их сургууль¹¹², Баруун Австралийн их сургууль¹¹³, Канберрагийн технологийн институт¹¹⁴ Свинбурнийн их сургууль¹¹⁵ зэрэг дээд боловсролын байгууллагууд дипломын сургалт явуулдаг.

¹⁰²<http://www.cqu.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰³<http://www.vu.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰⁴<http://www.qut.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰⁵<http://www.deakin.edu.au/forensic>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰⁶<http://chemistry.curtin.edu.au/courses/forensic.html>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰⁷<http://adminwww.flinders.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰⁸<http://www.newcastle.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹⁰⁹<http://www.gu.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹¹⁰<http://www.latrobe.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹¹¹<http://www.monash.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹¹²<http://www.psych.unimelb.edu.au/courses/pgrad/forinfo.html>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹¹³<http://www.forensicscience.uwa.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28..

¹¹⁴<http://www.cit.act.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

¹¹⁵<http://domino.swin.edu.au>. Сүүлд үзсэн огноо: 2015.05.28.

Эдгээр сургуулийг төгссөн этгээдүүд нь шүүх шинжилгээний төв, лабораториудад орон тооны буюу бүтэн цагаар, орон тооны бус буюу хагас цагаар ажилладаг байна. Энд урт хугацааны хөдөлмөрийн гэрээ болон тодорхой шинжилгээний ажилд тодорхой хугацаагаар хөлсөөр ажиллах эсхүл түүнтэй ижилтгэх бусад төрлийн гэрээгээр ажилладагсдын аль аль нь хамаарна.

3.4.3 Хууль тогтоомж

Шүүх шинжилгээний эрх зүйн үндсэн эх сурвалжид эрүүгийн хууль тогтоомж чухал байр эзэлдэг. Үүнд Эрүүгийн хууль голлох нөлөөтэй (гэмт хэргийн ул мөрийг тогтоохтой холбоотой шүүх шинжилгээ). Австрали улсад шүүх шинжилгээний асуудлыг, тэр тусмаа шүүх шинжилгээний институцийн бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, шинжээчийн эрх зүйн байдал зэргийг нарийвчлан зохицуулсан бие даасан хууль хараахан батлаагүй байна.

3.4.4 Дүгнэлт

Шүүх шинжилгээ нь талбарын шинжилгээ (хэргийн газрын шинжилгээ гэх мэт), лабораторийн шинжилгээ (ДНХ, хор судлал зэрэг), анагаахын шинжилгээ (патологи гэх мэт) гэсэн гурван категорьт хуваагддаг олон салбар дамнасан, хоёрдмол шинжтэй шинжлэх ухаан юм. Эдгээр нь тус бүртээ өөрийн судалгаанысалбар, судлах зүйлтэй боловч бүхэлд нь цогц байдлаар авч үзэх нь шинжилгээг боломжит бүх талаас иж бүрнээр хийхэд зохих үр дагавартайд тооцогддог.

Австрали улсад шүүх шинжилгээ нь дотроо олон салбар бүхий цогц шинжлэх ухаан байдлаар хөгжиж байгаа бөгөөд энэ шинжлэх ухааны ололтыг хууль сахиулах, тэр тусмаа гэмт хэргийг илрүүлэн тогтооход өргөн ашигладаг болох нь цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бие даасан болон харьяа шүүх шинжилгээний олон тооны судалгааны төв ажилладагаас харагдаж байна.

Институцийн хувьд шүүх шинжилгээний асуудлыг улсын хэмжээнд хариуцсан Шүүх шинжилгээний хүрээлэн ажилладаг бөгөөд улсын хэмжээнд шүүх шинжилгээний зохион байгуулалтын асуудлыг хариуцсан байгууллага юм. Гэхдээ санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд улсын төсвөөс хамааралтай. Бие биентэйгээ нягт хамааралтай ажилладаг бүтэцтэй (эрдэм шинжилгээнээс захиргааны аппаратыг хүртэл чадмаг холбосон), институцийн хувьд сайн зохион байгуулалттай.

Нөгөө талаас энэ салбарт төрийн байгууллага давамгайлдаг учраас төрийн монополь ноёрхох хандлагатай байна. Мөн ихэнх шүүх шинжилгээний төв, лабораториуд нь цагдаагийн байгууллагын дэргэд, түүний харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа нь цагдаагийн байгууллагаас хараат байдалтай болгох /бодит байдал дээр ийм байдалд хүргэж байгаа/ эрсдэлтэй байна.

4 ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Шүүх шинжилгээ” судалгааны ажлын хүрээнд шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, мэргэжлийн шинжээч, албан хаагчдын эрх зүйн байдлын зохицуулалт, шинжилгээний байгууллагын хийж гүйцэтгэж буй шинжилгээний төрөл болон түүнээс гарч буй магадлагаа, дүгнэлтийн баталгаат байдлын тал дээр илүү анхаарал хандуулан судалсан.

Судалгаанд Монгол Улсын шүүх шинжилгээний байгууллагын үүсэл хөгжил, өнөөгийн нөхцөл, цаашдын хөгжлийн чиг хандлагыг судалж нөхцөл байдалд дүгнэлт хийлээ. Мөн гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаа ямар чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилттэйгээр явагддаг, эдгээр асуудлыг зохицуулсан эрх зүйн орчин ямар байдаг талаар судлахдаа постсоциалист орнуудаас Унгар, шинэ хууль хэрэгжүүлж буй орнуудаас Эстони, техник технологийн дэвшлээрээ тэргүүлж буй орнуудаас Солонгос, өндөр хөгжсөн орнуудаас Австрали улсыг тус тус сонгон судалсан юм.

Шүүх шинжилгээний байгууллагын үүсэл хөгжлийн хувьд ихэнхи орны тухайдХХ зууны эхэн үеэс манайхтай адил тухайн улсын цагдаагийн байгууллагын аль нэг газар, хэлтсийн харьяанд, тэдний мөрдөн шалгах,гэмт хэрэг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэхажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор шүүх шинжилгээний баг ажиллуулснаар эхэлсэн байна. Эхэн үед ялангуяа гарын хээ, ул мөрийн шинжилгээ, шүүх эмнэлгийн шинжилгээ хийх, гэрэл зургаар эд мөрийн баримтыг бэхжүүлэх, мэдээлэл, адилтгалын нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлж байсан. Эдгээр шинжилгээний үр дүнд гарсан магадлагаа, дүгнэлт бодит нөхцөл байдлыг илрүүлэхэд шүүх, цагдаагийн байгууллагын ажилд ихээхэн хувь нэмэр үзүүлдэг байсан байна.

Шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтад суурилсан үйл ажиллагаа явуулдаг шүүх шинжилгээ тогтвортой хөгждөг бөгөөд тухайн орны улс төрийн байдал, эрх зүйн тогтолцооноос хамаарах нь харьцангуй бага хэдий ч зарим тохиолдолд, жишээлбэл социалист орнуудад өрнөсөн хэлмэгдүүлэлтийн үед улс төрийн ашиг сонирхолд нийцүүлэх зорилгоор шинжлэх ухааны үндэслэл бүхий шүүх шинжилгээний дүгнэлт, магадлагааг хэрэглэхгүй, шаардахгүй байсан түүх бий. Харин хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэх зэрэг үнэт зүйлстэй ардчилсан нийгэмд шилжсэнээр хэн нэгнийг гэмт хэрэгт сэжиглэх, мөрдөн байцаах зэрэг ажиллагаанд тавигдаж буй үндсэн шаардлагын нэг нь яах аргагүй бодит үнэнд тулгуурласан нотлох баримт бүрдүүлэх явдал болсон юм. Эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг мэргэжлийн шинжээчийн гаргасан дүгнэлт, магадлагаанд үндэслэн шийдвэрлэдэг болсноор тэдний хүлээх үүрэг хариуцлагын хэмжээ нэмэгдсээр байна.

Аливаа улс орны нийгэм, эдийн засгийн байдал тухайн оронд гарч буй гэмт хэргийн гаралтын өсөлт, бууралт, түүнийг үйлдэж буй арга барил, хэлбэрийн өөрчлөлттэй шууд харилцан хамааралтай байдаг. Тухайлбал тухайн улсад дайн, эмх замбараагүй байдал үүсэх, эдийн засгийн сөрөг нөлөө буюу ажилгүйдэл, ядуурлын хэмжээ өсөхийн хэрээр гэмт хэргийн тоо үлэмж хэмжээгээр өсдөг. Мөн ХХI зуунаас эхлэлээ авсан даяаршлын эринд хүмүүс хил хязгааргүй зорчих, хил дамнасан ажил үйлчилгээ эрхлэх, худалдаа хийх эрхээ бүрэн эдлэх боломж бүрдсэн, техник технологийн шинэчлэл эрчимтэй өрнөж шинэ үеийн ухаалаг электрон бараа бүтээгдэхүүнийг хүн бүр хэрэглэх болсон зэрэг нь гэмт этгээдүүдийн үйлдэл нь улам шинэлэг, боловсронгуй, далд хэлбэртэй болоход нөлөөлж байна. Нийгэм, эдийн засгийн харилцан адилгүй түвшинд үйл ажиллагаа явуулж буй шүүх шинжилгээний байгууллагууд техник технологийн болон боловсон хүчний мэдлэг, ур чадварын хувьд ч мөн адил дээрхи хөгжлийн түвшинтэй эн зэрэгцэх, шинжлэх ухааны шинэ арга зүй ашиглах, шинэ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл дээр ажиллах, байгаа боломжоо байнга сайжруулах шаардлага үүсдэг нь тодорхой.

Манай улсын хувьд гадаад орнуудтай харьцуулахад өргөн уудам нутаг дэвсгэртэй, мал аж ахуй эрхлэн нүүдэлчин соёл иргэншлээр амьдарч буй хөдөө орон нутгийн иргэд, хүн амын тэн хагас нь төвлөрөн суурьшсан хот суурин газрын иргэдийн дундбуюу хоёр эрс тэс өөр орчинд үйлдэгдэж буй гэмт үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцож нотлох баримтад дүн шинжилгээ хийдгээрээ онцлог бөгөөд хүндрэлтэй юм. Жишээлбэл хот суурин газар гарсан хүн амины хэрэг, хөдөө алслагдсан аймагт гарсан хүн амины хэргийн мөрдөн

шалгах ажиллагааны явцад ул мөрийг тогтоох, түүнд шинжилгээ хийх, эд мөрийн баримтыг зохистой савлах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх цаг хугацаа гээд олон ялгаатай талууд гардаг. Хэдийгээр хүндрэлтэй нөхцөл олон боловч манай шүүх шинжилгээний байгууллага өөрийн техник технологи, боловсон хүчний нөөц бололцоондоо тулгуурлан үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн.

Монгол Улс дахь орчин цагийн шүүх шинжилгээний байгууллагын хөгжлийг 1958 оноос эхэлсэн, 1998 оноос шинжилгээний ажиллагаа лабораторийн системд шилжсэн гэж үздэг. Нийгэм, эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт орсон 1990 оноос хойш зөвхөн социалист орнууд гэлтгүй дэлхийн олон хөгжингүй оронтой харилцаа холбоо, хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажилах болсноор тус салбарын хөгжилд илэрхий ахиц гарсан байна. Тухайлбал ОХУ, Энэтхэг, Герман зэрэг орнуудад шинэ мэргэжилтэн бэлтгэх, мэргэжлийн шинжээчдээ мэргэшүүлэх, туршлага судлах ажлыг зохион байгуулж гадаад дотоодын хөрөнгө оруулалттайгаар тусгай шинжилгээний лабораториуд байгуулан дагнан мэргэшсэн шинжээчтэй болж байгаань шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа криминалистикийн шинжилгээнээс хэтэрч илүү өргөн утгаар хэрэглэгдэж буй шүүх шинжилгээ зүй/forensic science/-н хэлбэр, үзэл баримтлалталруу хөгжиж байна гэж үзэж болох юм. Манай улсын хувьд шүүх шинжилгээний байгууллага нь шинжилгээний төрөл, арга зүйн хувьд илүү криминологи талдаа, магадлах шинжилгээний төрлүүд нь криминалистикийн шинжилгээний тал дээр илүү хөгжсөн байгаагаа нь тус байгууллага хөгжлийн түүхэндээ үргэлж цагдаагийн байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж, нягт холбоотой ажиллаж ирснийг харуулж байна.

Шүүх шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тухайд.

Гадаад орнуудын туршлагаас харахад өмнө дурдсанчлан ихэнхи улсын шүүх шинжилгээний байгууллага цагдаагийн байгууллагын дэргэд үйл ажиллагаа явуулж эхэлсэн хэдий ч бүгд бие даасан, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, зарим шинжилгээний хувьд онцгой эрхтэй бөгөөд үндсэн үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажил, туршилт давхар гүйцэтгэдэг байгууллага болж хөгжсөн байна.

Ерөнхийдөө шүүх шинжилгээний байгууллага нь Хууль зүйн яамны эсхүл цагдаагийн ерөнхий байгууллагын харьяанд улсын төсвөөс санхүүжин үйл ажиллагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл шүүх шинжилгээ явуулах эрх мэдэл, институцийг төр өөртөө хадгалж үлддэг үндсэн бодлого үйлчилж байгаа бөгөөд төрөөс бусад этгээдэд ийм үйл ажиллагаа явуулах эрхийг олгохыг хориглосон жишээ /Эстони/ байхад нөгөө талаас зөвшөөрсөн /Унгар/ жишээ ч мөн байна. Тухайлбал Унгар Улсын Гэмт хэргийн мэргэжлийн шинжилгээ, эрдэм шинжилгээний хүрээлэн нь улсын төсвөөс санхүүждэг, төрийн үйлчилгээний байгууллага бөгөөд цагдаагийн байгууллагын хагас удирлагын дор үйл ажиллагаа явуулдаг томоохон бүтэц юм. Тус хүрээлэнгийн шинжилгээний лабораториуд шинжилгээний салбар тус бүрээр салбарлан хөгжсөн, тус лабораториудад ажиллаж буй шинжээчид тухайн чиглэлээр мэргэшин үйл ажиллагаа явуулдаг, улсын хэмжээнд мансууруулах бодис, ДНХ-ийн шинжилгээ болон мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад ул мөр, баримт бичиг, хими, физик, геологи, биологийн зарим шинжилгээ хийх онцгой эрх эдэлдэг нь хэрэг маргааныг мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллагад хүргэж буй мэргэжлийн шинжээчийн дүгнэлт, магадлагаа үнэн бодит мэдээлэл агуулсан байх баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тус улсад шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагаас гадна хууль тогтоомжид заасан мэргэжил, ур чадвар, ажлын туршлагын шаардлага хангасан хувийн өмчит хуулийн этгээд, хувь хүнд хууль зүйн мэргэжлийн шинжээчийн үйл ажиллагаа явуулах эрх олгодог тогтолцоо байдаг. Аливаа хэрэг маргааны оролцогч, эсхүл хууль сахиулах

байгууллага эдгээр хууль зүйн шинжээч, шинжилгээний байгууллагуудтай гэрээ хийсний үндсэн дээр шинжилгээ хийлгэх бүрэн боломтой байдаг нь шүүх шинжилгээний төв байгууллагын ажлын ачааллыг багасгах, хэрэг маргааныг хурдан шуурхай шийдвэрлэхэд нөлөөлдөг гэж үздэг байна.

Солонгос улсын шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоог харахад анх цагдаагийн байгууллагын нэгдсэн удирдлагад түүний үйл ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдаж байсан шүүх шинжилгээний байгууллага нь хөгжлийн явцдаа хоёр хуваагдсан байдаг. NFS нь улсын хэмжээнд шүүх шинжилгээний үйл ажиллагааг хариуцсан улсын төсвөөс санхүүждэг төв байгууллага бөгөөд яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь гэмт хэрэгтэй холбоотой үүссэн эд мөрийн баримтын, нотлох баримтад шинжилгээ хийж дүгнэлт гаргах болон бусад үйл ажиллагаагаараа цагдаагийн байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих явдал юм. Үүнээс гадна Прокурорын байгууллагын дэргэдэх “Үндэсний дижитал шүүх шинжилгээний байгууллага”, цэрэг болон далайн цагдаагийн байгууллагын дэргэд “Шинжлэх ухааны шүүх шинжилгээний байгууллага”, эргийн хамгаалалтын газрын дэргэдэх “Солонгосын эргийн хамгаалалтын хүрээлэн” тус тус мэргэжлийн шинжилгээний үйл ажиллагаа явуулж толгой байгууллагын хариуцсан асуудал, чиг үүргийн хүрээнд шүүх шинжилгээний ажил гүйцэтгэдэг байна. Эдгээр байгууллага, лаборатори нь тодорхой нэг чиглэлээр мэргэшсэн бөгөөд шинжилгээний үр дүн болох магадлагаа, дүгнэлтээ олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хийж гүйцэтгэх боловсон хүчин, техник технологийн хүчин чадалтай байдаг. Шинжилгээний ажлаас гадна шүүх шинжилгээний арга зүйг сайжруулахад чиглэсэн шинжлэх ухааны шинэ арга зүй, зарчим боловсруулах, техник технологийг хөгжүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх үүрэг хүлээсэн байдгаараа бусад улсаас онцлог байна.

Шүүх шинжилгээний байгууллага болон шинжээчдийн эрх зүйн зохицуулалтын тухайд.

Судалгааны ажилд сонгон авсан гадаад орнуудаас Унгар, Эстони улсуудад шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, мэргэжлийн шинжээчдийн эрх зүйн байдлыг бие даасан хуулиар зохицуулдаг бол Австрали, Солонгос улсуудад бие даасан хууль байдаггүй байна.

Мэргэжлийн шинжээчдийн эрх зүйн байдлыг хэрхэн зохицуулсан байдаг тухай энэ судалгаанд улс тус бүрээр дэлгэрэнгүй авч үзсэн. Үүнээс харахад шүүх шинжилгээний ажилтанг шүүхийн шинжээч, хууль зүйн шинжээч зэрэг олон янзаар тодорхойлох боловч үндсэн санаа болох гэмт хэрэг илрүүлэх, хууль сахиулах үйл ажиллагаанд шүүх, цагдаа, прокурорын байгууллагын ажлыг гаргасанд дүгнэлт, магадлагаагаар дамжуулан дэмжиж ажиллах үүрэгтэй болон хууль зүйн салбарт үйл ажиллагаа явуулах эрх бүхий мэргэжлийн шинжээчдийг ойлгож байна. Гадаад орнуудад шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулах албан ёсны эрх авсан мэргэжлийн шинжээчдийн нэгдсэн бүртгэлийг хөтөлдөг жишиг байх бөгөөд энэхүү нэгдсэн бүртгэлийг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг шүүх шинжилгээний байгууллага эсхүл хууль тогтоомжоор олгосон эрхийн дагуу шүүх шинжээчдийн холбоо, танхим хөтөлдөг байна. Ийм чиг үүрэг бүхий байгууллага нь нэгдсэн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага шинжээчдийн давтан болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох, ёс зүйн хариуцлага тооцох зэрэг захиргааны шинжтэй үүрэг хариуцлагыг давхар хүлээдэг байна.

Хууль зүйн салбарт үйл ажиллагаа явуулах эрх бүхий мэргэжлийн шинжээчдийг статусаар нь үндсэндээ 2 ангилж болно. Үүнд: *нэгдүгээрт*, улсын хэмжээний эсхүл мөрдөн байцаах, хууль сахиулах байгууллагын харьяа шинжилгээний байгууллагад ажиллаж буй мэргэжлийн шинжээч, *хоёрдугаарт*, албан ёсны хууль зүйн мэргэжлийн шинжээчийн эрх

авсны үндсэн дээр хувиараа үйл ажиллагаа явуулах эрх бүхий бие даасан шинжээч орж байна. Шүүх шинжилгээний төв байгууллагын ажлын ачааллыг багасгах зорилгоор эсхүл мэргэжлийн туршлага, онцгой мэдлэг шаардсан шинжилгээ хийлгэх шаардлагатай үед гэрээгээр ажил гүйцэтгүүлдэг, мөн хэргийн оролцогч өөрөө хүссэн тохиолдолд албан ёсны эрхтэй хөндлөнгийн мэргэжлийн шинжээч сонгодог хандлага олон улсын хэмжээнд тогтсон байна.

Мэргэжлийн шинжээчид тавих шаардлага шинжилгээний төрөл тус бүрт, улс болгонд харилцан адилгүй байна. Зарим улсад 3 жилийн бакалаврын зэрэг олгох сургалтад хамрагдсанаар шинжээч болох эрх нээгдэж байхад зарим улсад мэргэжил эзэмшсэнээс хойш мэргэжлээрээ ажилласантуршлагатай байх шаардлага хангасан тохиолдолд эрх олгодог зэрэг олон төрлийн зохицуулалт байна.Шинжээчийн хувьд шүүх шинжилгээний байгууллагад хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилладаг байнгын ажлын байр бүхий шүүхийн шинжээч, шаардлагатай тохиолдолд хөлсөөр ажилладаг, эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад бүртгэгдэж тодорхой хугацаатайгаар гэрчилгээ авдаг шинжээч гэсэн 2 төрөл байна.Мөн тухайн улсын шүүх шинжилгээний байгууллагад орон тооны шинжээчээр ажиллаж байгаа мэргэжлийн шинжээчид бусад байгууллага, хувь хүнл захиалгаар буюу гэрээгээр шүүх шинжилгээний ажил хийхийг хориглодог нийтлэг зохицуулалт байна.

Шүүх шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийн тухайд.

Шүүх шинжилгээний байгууллагууд үйл ажиллагаа болон боловсон хүчний чадавхи дээшлүүлснээр олон улсын стандартад нийцсэн шүүх шинжилгээний үр дүн буюу дүгнэлт, магадлагаа гаргахыг хэтийн зорилго болгон ажилладаг бөгөөд үүний тулд олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, шинэ техник технологи хөгжүүлэх, нэвтрүүлэх, шинжээч мэргэжилнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг байна. Энэ зорилгодоо хүрэхийн тулд дийлэнхи шүүх шинжилгээний байгууллага эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт хийх эрх, үүрэг хүлээдэг бөгөөд ийнхүү олж авсан шинэ мэдлэг, үр дүнгээ олон улсын хэмжээний хурал, зөвлөгөөн, форумд хэлэлцүүлж өөрслийн ур чадвар, үйл ажиллагааны түвшинг үнэлүүлдэг байна.

Шүүх шинжилгээ гэдэг нь өөрөө олон төрлийн шинжилгээний салбарын хамарсан цогц ойлголт учир олон улсын стандартад нийцүүлэн гэрчилгээ авна гэдэг амар зүйл биш гэдэг нь судалгааны ажлаас харагдаж байна. Шүүх шинжилгээний хүрээлэнд хийгдэж буй дактилоскоп, галт зэвсэг, баримт бичиг, микро эд, эсийн, мансууруулах бодисын, хими, физик, биологийн гээд бүхий л шинжилгээний төрөл болон түүнийг гүйцэтгэх арга зүй, лабораторийн тоног төхөөрөмжид тавигдах чанарын шаардлагыг салбар тус бүрээр нь тогтоосон байдаг тул нэг шүүх шинжилгээний хүрээлэн бүхий л шинжилгээний төрлөөр олон улсын стандартыг хангана гэдэг нь асар их хөрөнгө санхүү шаардсан ажил юм. Энд жишээ болгон Микробиологийн чиглэлээр шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулж байгаа лабораториудад олон улсын чанарын баталгаа олгоход шаарддаг тусгай стандартыг товч танилцуулж байна.

Тус стандартад шүүх шинжилгээ, сорилын үр дүн найдвартай, холбогдох мэдээллийг өгч байгаа эсэхийг шалгахад чиглэсэн мониторингийн үйл ажиллагаа хамаардаг. Стандартын дагуу лабораториудад тавигддагминимум шаардлага /Хавсралт 3/ буюу Чанарын баталгааны хөтөлбөр, Зохион байгуулалт, менежмент, Хүний нөөц, Тоног төхөөрөмж, хөдөлмөрийн аюулгүй байдал, Сорьцын хяналт, Хүчинтэй байдал/баталгаа, Аналитик процедур, Тохируулга, үйлчилгээ (үйл ажиллагааны хэвийн горимыг хадгалах), Мэдлэг, ур чадварыг үнэлэх шалгалт, Засварын үйл ажиллагаа, Баримтжуулалт, тайлан бичилт, Тайлан хянах, Аюулгүй байдал, Аудитын шалгалт хийх тогтолцоотой байх зэрэг шаардлага тавигддаг байна.

Төгсгөлд нь дүгнэхэд шүүх шинжилгээ нь дотроо олон салбар бүхий цогц шинжлэх ухаан байдлаар хөгжиж байна. Шинжлэх ухааны ололтыг хууль сахиулах, тэр тусмаа гэмт хэргийг илрүүлэн тогтооход өргөн ашигладаг болох нь бие даасан үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын харьяа болон хувийн хэвшлийн шүүх шинжилгээний олон тооны судалгааны төв ажилладагаас харагдаж байна. Эдгээр шинжилгээний байгууллагад ажиллаж буй мэргэжлийн шинжээчдэд гэрчилгээ олгож нэгдсэн бүртгэлд бүртгэдэг олон улсын жишиг тогтсон байна гэж дүгнэж байна.

САНАЛ

Судалгааны ажлын үр дүнд олж авсан мэдээлэлд тулгуурлан Монгол Улсын шүүх шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, боловсон хүчин, эрх зүйн орчин болон бусад асуудлын хүрээнд дараах судлаачийн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулах үндсэн эрх мэдэл, институцийг төр өөрийн мэдэлд хадгалж үлдэх ба төрөөс санхүүжүүлдэг байх. Мөн зарим төрлийн шүүх шинжилгээ хийх онцгой эрхийг шүүх шинжилгээний төв байгууллагад олгох;
2. Шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэгт зөвхөн шүүх шинжилгээ хийхээс гадна эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт хийх үүрэг хүлээлгэх замаар байгууллагын болон мэргэжлийн судлаачдын мэдлэг, ур чадвар, байгууллагын нэр хүндийг өсгөх боломжоор хангах;
3. Шүүх шинжилгээний салбарыг хөгжүүлэх эрх зүйн болон эдийн засгийн цогц арга хэмжээ авах замаар бусад төрийн байгууллага болон хувийн өмчийн хуулийн этгээдийн дэргэд шүүх шинжилгээний лабораториуд хөгжих боломж бүрдүүлэхэд анхаарах;
4. Хууль сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулж буй шинжээчдийн эрх зүйн байдлыг сайжруулсан, тэдний үйл ажиллагааны чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон бие даасан эрх зүйн зохицуулалттай болгох;
5. Тухайн салбарт онцгой мэдлэг, мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан шинжилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд гэрээгээр шинжээч ажиллуулах нөхцөлийг тодорхой тусгасан эрх зүйн зохицуулалттай болох;
6. Хууль зүйн салбарт шүүх шинжилгээний үйл ажиллагаа явуулах мэдлэг, ур чадвартай боловсон хүчний буюу мэргэжлийн шинжээчдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;
7. Энэхүү нэгдсэн бүртгэлд зөвхөн хууль зүйн салбарт хууль тогтоомжид заасан тодорхой мэргэжлээр, тодорхой мэргэжлийн шаардлага хангасан шинжээчдийг бүртгэж, шинжээчийн эрхийн гэрчилгээ олгодог байх;
8. Шүүх шинжилгээний байгууллагад гүйцэтгэж буй шинжилгээ тус бүрийн үнэ, тарифийг тогтоох, аргачлал боловсруулах замаар жишиг тариф гаргах, түүнийг ашиглах аргачлалыг олон нийтэд нээлттэй болгох. Ингэснээр иргэд шүүх шинжилгээний байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төлбөр, тооцооны талаар бүрэн мэдээлэл авах бөгөөд гэм буруу нь тогтоогдсон этгээдээс дээрх төлбөрийг гаргуулж нэгдсэн санд төвлөрүүлдэг байх;
9. Шинжээчдийн тогтвортой ажиллах нийгмийн баталгааг бүрдүүлэх зэрэг асуудал багтаж байна.